“Анхан болон давж заалдах шатны шүүхийн
Тамгын газрын үйл ажиллагааг үнэлэх журам”-ын
2 дугаар хавсралт

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

НЭГ. УДИРТГАЛ

1.1. Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого, Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн жил хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн тэргүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. Шүүхийн бие даасан байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ
 Дүн шинжилгээ

2.2. Шүүхийг хүний нөөцөөр хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ
 Дүн шинжилгээ

2.3. Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ
 Дүн шинжилгээ

2.4. Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ
 Дүн шинжилгээ

2.5. Мэдээллээр хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ
 Дүн шинжилгээ

ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ САЙЖРУУЛАХ САНАЛ

ДӨРӨВ. ХАВСРАЛТ

4.1. Тамгын газрын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

4.2. Тухайн жилийн үйл ажиллагааны тайланд шүүгч, ажилтны өгсөн үнэлгээ /хурлын тэмдэглэл/ шүүгч нарын зөвлөгөөний тогтоол

НЭГ. УДИРТГАЛ

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн Тамгын газар нь Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс Монгол Улсын Шүүхийн хэмжээнд дэвшүүлсэн зорилго, зорилтыг тус шүүхэд хэрэгжүүлэх, шүүхийн үйлчилгээ, хэргийн хөдөлгөөний удирдлагын чанарыг дээшлүүлэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах, шүүхийн захиргаа, хэргийн хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтыг хэрэгжүүлж шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг ханган ажиллалаа.

Тус шүүх нь Завхан аймгийн баруун хойд талд байрлах 9 сумыг харъяалан үйл ажиллагаа явуулж байна.

Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын “Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшүүлэх” зорилтын хүрээнд тус шүүхийн хараат бус байдлыг хангуулах, шүүхийн үйлчилгээг хариуцлагатай явуулах, иргэд олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулахад онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. Энэ хүрээнд харъяа тойргийн 9 суманд нээлттэй өдөрлөг зохион байгуулж, шүүх, шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны талаар иргэд олон нийтэд мэдээлэл өгч, тус шүүхийн шүүн таслах ажиллагааны талаарх тоон мэдээллийг өөрийн шүүхийн веб сайт болон фейж хуудсанд байршуулан ажиллалаа.



Шүүхийн иргэдэд үйлчлэх хэсгийг өөрсдийн дотоод нөөц боломжоороо засварлаж, шүүхийн үйлчилгээг тав тухтай орчинд иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг хангах, хэргийн хөдөлгөөний удирдлагын чанарыг дээшлүүллээ.

Тайлант хугацаанд 2 шүүгч /1 шүүгч 2024.03.20-ны өдрийг хүртэл/, 1 тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, 1 мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, 1 мэдээлэл технологийн мэргэжилтэн, 2 шүүгчийн туслах, 2 шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, 1 ахлах нягтлан бодогч, 1 нярав, 1 эвлэрүүлэн зуучлагч, 1 эвлэрүүлэн зуучлагчийн туслах, 1 бичиг хүргэгч, 1 архив бичиг хэргийн эрхлэгч, 1 жолооч, 1 үйлчлэгч, 3 галч, 1 гэрээт ажилтан нийт 18 шүүхийн захиргааны ажилтан, албан хаагчийн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явууллаа.

ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. Шүүхийн бие даасан байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

2.1.1. Нийт шүүгчийн чуулганы 2021.10.11-ний өдрийн 05 дугаартай тогтоолоор баталсан “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам”, тус шүүхийн 2023.12.27-ны өдрийн 01 дугаартай “Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол”-ын дагуу тайлант хугацаанд шүүхэд ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хэргийн хөдөлгөөний нэгдсэн системд хэрэг хуваарилах журмын дагуу бүртгэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аргачлал журмын хэрэгжилтийг ханган ажилласан.





ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ 208 ДУГААР ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ДУРДСНААР СУМ ДУНДЫН 8 ШҮҮХ БОЛОН АЙМАГ ДАХЬ ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ, МАРГААНЫ ТОО

				/2023.12.09-2024.06.14/					
				Бусад шийдвэрлэлт					
№	Шүүхийн Тамгын газрын нэр	Шүүхийн нэр	Шүүгчийн нэр	Хянан магадлан шийдвэрлэсэн тоо	зөрчлийн хүсэлт	Эрүүгийн гэрээ болон албадан гүйцэтгүүлэх хүсэлт батлагаажуулсан	өөр шүүхэд бүрэлдэхүүнд орсон	даалгаваар гүйцэтгэх	сумдад томилолтоор ажилласан
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Завхан аймаг Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газар	Завхан аймаг Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	Б.Уртнасан	1	3	48	0	1	5
2	Завхан аймаг Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газар	Завхан аймаг Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	Б.Өлзийхишиг	1	7	48	3	2	4
3	Завхан аймаг Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын	Завхан аймаг Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	Ж.Оттгонхишиг	0	5	14	0	0	0

2.1.2. Тус шүүхийн шүүгч нарын 2024 оны хагас, бүтэн жилийн байдлаарх шийдвэрлэсэн хэргийн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарыг судалгаа гаргаж Ерөнхий шүүгчид танилцуулан Шүүхийн ерөнхий зөвлөлд 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр 2024.06.17-ны өдрийн 141/ЗТ2024/00035 дугаартай шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын хамт цахимаар хүргүүлсэн байна.

2.1.3. Тус шүүхийн шүүн таслах ажиллагааны 1, 2, 3, 4-р улирлын тоон мэдээлэл болон шүүхийн тамгын газраас авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаар сар бүрийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын зөвлөгөөнд танилцуулж, шүүгчдийн зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд зохион байгуулсан шүүгч ажилтнуудын 6 удаагийн зөвлөгөөнд танилцуулга мэдээлэл хийж ажилласан байна.



2.1.4. Тус шүүхийн шүүн таслах ажиллагааны 2023 оны бүтэн жил, 2024 оны 1, 2, 3 улирлын тайлан мэдээг гарган Шүүхийн ерөнхий зөвлөлд цаасаар болон цахимаар хугацаанд нь хүргүүлж ажилласан. Хэргийн хөдөлгөөний удирдлагын E-CASE системд 1-11 хүртэлх сарын мэдээ 2024 оны 1, 2, 3 улирлын мэдээг оруулж ажилласан.

2.1.5 Иргэний 157, эрүү болон зөрчлийн 1247, цагдан хорих 22, хянан магадлан 3 нийт 1429 шүүх хуралдааны бэлтгэлийг хангаж, шүүх хуралдааны тов, тоймыг тухай бүр https://live.shuukh.mn/ -д байршуулж, өөрийн шүүхийн цахим хуудаст холбосон байна.



2.1.6. Хэргийн оролцогч нарыг зайнаас шүүх хуралдаанд оролцох нөхцлөөр хангах “Зүүм” программаар иргэний 44, зөрчлийн 12, эрүүгийн 39, цагдан хорих 9 нийт 104 хүнийг цахимаар шүүх хуралдаанд оролцуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

2.1.7. Шүүхийн шийдвэрийг цахим хуудас www.shuukh.mn -т холбогдох журмын дагуу тогтоосон хуулийн хугацаанд нь эрүүгийн хэргийн 73 шийтгэх тогтоол, иргэний хэргийн 168 шийдвэрийг тус тус байршуулсан байна.



Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 94 дугаар тогтоолоор “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр баталсан. Уг журмаар шүүхийн тамгын газраас 2024.05.29-ний өдөр дахин сургалт орсон. Тус шүүхийн шүүгчийн туслахууд шийдвэрийг шүүгч гарын үсэг зурж албажуулснаас хойш ажлын 10 хоногт багтаан шүүхийн шийдвэрийн цахим хуудаст байршуулах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар шийдвэрийг дугаарын дараалаар болон техникийн шаардлага хангаж оруулсан эсэхийг нягтлан шалгах, мэдээлэл технологийн мэргэжилтэн, тамгын газрын дарга нар хяналт тавин ажиллахаар болсон.

2.1.8. Тайлант хугацаанд шүүхийн шийдвэр, шүүхийн мэдэгдэх хуудас, эрүүгийн гүйцэтгэх хуудас, иргэний гүйцэтгэх хуудас, эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэл, зэрэг шүүгчээс гарсан **2347** эрх зүйн актыг хэргийн оролцогчдын тоогоор байгууллага, иргэдэд хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажилласан байна.

2.1.9. Шүүн таслах ажлын төрлөөр холбогдох мэдээллийг бүртгэл, хяналтын нэгдсэн системд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрээр цаг тухайд нь оруулж, бүртгэл хөтлөн, мэдээллийн сан бүрдүүлэн хэргийн хөдөлгөөний нэгдсэн системээс шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд холбогдох мэдээллийг харах, мэдээ тайлан гаргах, ашиглах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн системд алдаа гаргасан тохиолдолд тухай бүр хүсэлтийг хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэст хүргүүлэн ажилласан байна.



2.1.10. Хавтаст хэрэг илгээх, хүлээн авах журмын хэрэгжилтийг хангаж, нийт **25** хэргийг шүүх хооронд илгээх, шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавин ажиллалаа. Үүнд:

Давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүхэд хүргүүлсэн хэргийн тоо

ХЭРГИЙН ТӨРӨЛ	ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭД	ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭД	НИЙТ
ИРГЭНИЙ ХЭРЭГ	6	4	10
ЭРҮҮГИЙН ХЭРЭГ	8	3	11
ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ	4		4
НИЙТ	18	7	25

<u>Тамгын газар шүүхийн иргэдийн төлөөлөгчийн чиглэлээр:</u>

2.1.11. МУШтХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан иргэдээс нэрсийн жагсаалтыг гаргаж баталгаажуулж, 2022-2024 онд сонгогдсон 159 иргэний мэдээллийн санг бүрдүүлсэн. 2024-2026 онд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон 330 иргэний нэрсийг холбогдох нутгийн захиргааны байгууллагатай хамтран нягталж шалган шүүхийн тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/22 тоот тушаалаар баталгаажуулж, ШЕЗөвлөлд хүргүүлэн шүүх хуралдаанд оролцох бүрэн эрхийг хангуулан ажиллаж байна.

2.1.12. Монгол Улсын шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсэгт заасны дагуу шүүх хуралдааны тов гармагц иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтаас шүүх хуралдаан бүрд 10 хүний нэрсийн дэд жагсаалтыг цахимаар эрэмбэлэн тохиолдолын журмаар сонгон тамгын газрын даргын тушаалаар батлуулан ажиллаж байна. Шүүх хуралдаан товыг ажлын 5 доошгүй өдрийн өмнө мэдэгдэх хуудас болон утсаар иргэдийн төлөөлөгч нарт мэдэгдсэн. 2024 онд иргэний хэрэгт **6**, эрүүгийн хэрэгт **6** нийт 12 иргэдийн төлөөлөгч сонгогдож шүүх хуралдаанд оролцсон байна. Иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага, шүүх хуралдааны дэгийн талаар мэдээлэл өгөх ажлыг шүүгчийн туслахууд хариуцан хэрэгжүүлж, холбогдох баримтыг хэрэгт хавсарган ажиллаж байна.

2.1.13. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлын талаар https://court.tosontsengel.za.gov.mn өөрийн шүүхийн цахим хуудаст байршуулсан байна.



2.1.14. Завхан аймгийн Тосонцэнгэл, Тэлмэн, Их-Уул сумын иргэдэд 20240.04.26-ны өдөр, Нөмрөг, Түдэвтэй, Баянхайрхан, Асгат, Баянтэс, Тэс сумуудад 2025.05.06-05.10-ны өдрүүдэд иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлын талаар таниулах ажлыг иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэдэд болон тойргийн сумдад зохион байгуулсан нээлттэй өдөрлөгийн үеэр нийт давхардсан 2100 гаруй иргэдэд сургалт зохион байгуулж гарын авлага тарааж ажилласан байна.

Тамгын газар эвлэрүүлэн зуучлалын чиглэлээр:

2.1.15. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Ерөнхий зөвлөл болон Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 154 өргөдөл, нэхэмжлэл хүлээн авч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан байна.

2.1.16. Тус шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд хандаж хүлээн авсан өргөдөл, шийдвэрлэсэн маргааныг 2023 онтой харьцуулсан байдал:



2.1.17. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр нөлөөг сайжруулах ажлын хүрээнд Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн хамт олонд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль болон Эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны давуу тал сэдвээр сургалт орж, гарын авлага тарааж, тэдний сонирхсон асуултад хариулж, харилцан яриа өрнүүллээ.

2.1.18. 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдөр, 2024 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 11 дүгээр сарын 23-ны өдрийн хооронд тойргийн 6 сум буюу Нөмрөг, Түдэвтэй, Баянхайрхан, Асгат, Баянтэс, Тэс, сумдад нүүдэллэн ажиллаж, “Нээлттэй шүүх” өдөрлөг зохион байгуулж, 75 өргөдөл хүлээн авч, сумын мэдээллийн самбарт байрлах эвлэрүүлэн зуучлалын мэдээллүүдийг шинэчилсэн байна.





2.1.19. Эвлэрлийн гэрээний төслийг ирсэн өргөдлийн дагуу Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаар боловсруулан ажиллаж байна. Гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахаас татгалзсан тохиолдолд түүний үндэслэлийг харгалзаж дахин талуудыг дуудан ажиллагааг явуулдаг бөгөөд тайлант хугацаанд 139 эвлэрлийн гэрээ байгуулж, шүүхэд шилжүүлж шүүгчийн захирамжаар баталгаажуулсныг 278 байгууллага иргэнд гардуулан ажилласан байна.

2.1.20. Хугацаа хэтрэлтээс сэргийлэх үүднээс шүүгч тус бүрээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хэрэг болон эрх зүйн актын түүвэр гаргаж 7 хоног бүрийн ажилтнуудын шуурхай, сар бүрийн шүүгч, ажилтнуудын зөвлөгөөнд тогтмол танилцуулж, мөн өдөр бүр хугацаа дөхсөн хэрэг, эрх зүйн актын талаар шүүгч, ажилтнуудад мэдэгдэж, программ хангамж ашиглах нөхцөл, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж байна.

Дугаарын бүртгэл

Шүүгчийн захирамж

2024

№	Дугаар	Огноо	Хэргийн дугаар	Нэр
1	2024/ШЗ/01	2023/12/22	2324000000085	БААТАР НЯМДОРЖ
2	2024/ШЗ/02	2023/12/28	2324000000056	
3	2024/ШЗ/03	2023/12/28	2324000370080	БАЯРЖАВХЛАН ГОМБОСҮРЭН
4	2024/ШЗ/04	2024/01/02	2324000440054	БИЛЭГДЭМБЭРЭЛ ДАГИЙДЭМЭД
5	2024/ШЗ/05	2024/01/02	2324000000085	БААТАР НЯМДОРЖ
6	2024/ШЗ/06	2024/01/02	2324000620068	ЭРДЭНЭБААТАР ГЭРЭЛМАА

	141/ШШ2024/00238	2024-11-28	Шийдвэр
	141/ШШ2024/00237	2024-11-28	Шийдвэр
	141/ШШ2024/00236	2024-11-28	Шийдвэр
	141/ШШ2024/00235	2024-11-28	Шийдвэр
	141/ШШ2024/00234	2024-11-28	Шийдвэр
	141/ШШ2024/00233	2024-11-28	Шийдвэр
	141/Ш32024/00911	2024-11-29	Шүүгчийн захирамж
	141/Ш32024/00904	2024-11-27	Шүүгчийн захирамж
	141/Ш32024/00903	2024-11-25	Шүүгчийн захирамж
	141/Ш32024/00902	2024-11-25	Шүүгчийн захирамж

МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр Дугаар 158 Улаанбаатар хот

Хэргийн хөдөлгөөний хяналтын журам
батлах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.5, 71.1.8, 71.1.13 дахь заалт, 79 дүгээр зүйлийн 79.1, 79.5 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1."Хэргийн хөдөлгөөний хяналтын журам"-ыг 1 дүгээр, "Зөрчлийн шалгуурын маягт"-ыг 2 дугаар, "Алданы шалгуурын маягт"-ыг 3 дугаар, "Дотоод хяналт шалгалтын маягт"-ыг 4 дүгээр, "Дотоод хяналт шалгалтын тайлангийн загвар"-ыг 5 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

2."Хэргийн хөдөлгөөний хяналтын журам", "Зөрчлийн шалгуурын маягт", "Алданы шалгуурын маягт", "Дотоод хяналт шалгалтын маягт", "Дотоод хяналт шалгалтын тайлангийн загвар"-ыг үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллахыг шүүхийн Тамгын газрын дарга нарт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба /Б.Эрдэнэтуяа/-нд тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг батлагдсантай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дүрэм 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 29 дүгээр тушаал, 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 50 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгохыг Шүүхийн зөвлөлийн дарга /Л.Энхбилэг/-д даалгасугай.

4.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА Л.ЭНХБИЛЭГ

2.1.21. Тус тамгын газрын даргын 2024.04.19-ний өдрийн А/11 дугаартай “Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай” тушаалаар 2024 оны хагас жилийн дотоод хяналт шинжилгээг хийж, илтгэх хуудас гаргуулан ажиллаж тус шүүхийн шүүгч нарт танилцуулж ажилласан.

ШЕЗ-ын 2024.06.13-ны өдрийн 158 дугаар тогтоолоор батлагдсан “Хэргийн хөдөлгөөний хяналтын журам”-д заасны дагуу сар бүр хяналт шалгалтыг хийж, шүүгч нарт танилцуулж, 2024 оны 03 дугаар улирлын тайланг ШЕЗ-д хүргүүлсэн байна.

<u>Тамгын газар шүүхийн мэдээллийн технологийн чиглэлээр:</u>

2.1.22. ШЕЗөвлөлөөс 2024 онд ирүүлсэн Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс өгсөн 15 Антивирусны программыг суулгаж ажилласан байна. Үүнд: 2 шүүгч, тгд, 2 туслах, 2 нарийн бичгийн дарга, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, мэдээлэл технологийн мэргэжилтэн эвлэрүүлэн зуучлагч, 2 хурлын заал, ахлах ня-бо, нярав нийт 15 компьютерт суулгаж өгсөн бөгөөд бусад техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг тогтмол хангаж, шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, техник хангамжид гарсан эвдрэлийн засвар үйлчилгээг тухай бүрд хийж гүйцэтгэсэн. Цахилгаан тасраад сервер унтраад асах үед цаг буруу явж эхэлдэг. Төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд тогтмол хяналт тавьж цаг зөв ажиллаж байгаа эсэх дээр цахилгаан тасарсан тохиолдол бүрд хяналт тавьж анхааран ажиллаж байна. Мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, Иргэн-2014 R210 серверийг нэгдсэн дотоод сүлжээндээ ашиглаж түүнд хандсан хэрэглэгчдийн хэрэгцээтэй файл, өгөгдөл

/дата/, баримт, мэдээллийн сан зэргийг 2023 оны 12 сард 583GB файл, 2024 оны 6 сард дахин нөөцөлж 617GB файл хадгалж авсан байна. Тухайн шүүхийн хуучин сүлжээний төхөөрөмж болох switch /сүлжээний төхөөрөмж/-ийг 2023 оны 12 сард 1000Mbps хурдтай төхөөрөмжөөр switch /сүлжээний төхөөрөмж/ сольж, сүлжээний план зураг шинэчлэн гаргасан, сүлжээний хаягжилтыг шинээр хийсэн байна.

2.1.23. Шүүхэд мэдээллийн технологийг ашиглахтай холбогдсон хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг тогтмол зохион байгуулж Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем” сэдэвт сургалт зохион байгууллаа.

2.1.24. Шүүх хуралдааны бичлэгийг 2013 оноос одоог хүртэл архивлаж байгаа бөгөөд тусгайлан бүртгэлийн дэвтэр хөтөлж шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нараар 7 хоног бүр гарын үсэг зуруулан баталгаажуулдаг бөгөөд хатуу дискэнд 9730 бичлэг архивлагдан шүүхийн серверийн өрөөнд хадгалагдаж байна. 2024 онд шинээр 1224 хурлын бичлэг хадгалсан. Үүнд: Иргэн 185, эрүү 341, зөрчил 644, цагдан хорих 47, хянан магадлан 7 бичлэг байна.

2.1.25. Тус шүүхэд ашиглагдаж байгаа нийт 20 компьютер, 5 нөүтбүүк 12 принтерийн нь эвдэрхий, нийт 16 камер, 2012 оны зургийн аппарат 1 ширхэг, зөөврийн хард 4 ширхэг байна. 2024 онд батлагдсан төсвөөс шинээр суурин компьютер 1 ширхэг, принтер 2 ширхэг, УДШ блансаас блансад шилжүүлж авсан зөөврийн компьютер 1 ширхэг, принтер 1 ширхэг ШЕЗ өгсөн шүүх хуралдааныг шууд дамжуулах төхөөрөмж, хурлын бичлэг хадгалах хард 2 ширхэг шинээр хүлээн авсан байна. Шүүгч Ж.Отгонхишиг нь давж заалдах шатны шүүх рүү шилжин явсан холбоотой түүний албан хэрэгцээнд ашиглаж байсан зөөврийн компьютерыг Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газарт блансаас блансад шилжүүлэн өгсөн байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 612 дугаартай Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй цаашид

ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг данснаас хасахыг зөвшөөрсөн тухай тогтоолын дагуу хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг зохион байгуулж, данснаас дараах техник тоног төхөөрөмжтэй холбоотой Камерын серверийн хайрцаг, Компьютер DELL3020, Дотор кабель, Гадна кабель, Сүлжээний толгой тємєр, Далдлагч, Сүлжээ салаалагч, Зургийн аппарат, ог бууруулагч, Сүлжээний гадна камер, Сүлжээний дотор камер, Принтер M1212, Samsung 3400 принт, Dell PC, Канон, Dell optiplex3010, ASER Компьютер, BSB компьютер, Зөөврийн компьютер hp, Мотор yamaha, Зөөврийн компьютер, Хөл TH-X, Камер/Panasonic HC-VX985/ хөрөнгүүдийг устгасан байна.



2.1.26. Шүүхийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, кибер халдлага, хортой код, спам, вирусээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр тухай бүр мэдээлэл өгч, шүүхийн имейл хаягт илэрсэн хортой код, спам, вирусыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажиллаж байна. Тайлант хугацаанд тус шүүхийн имейл хаягт ирсэн **3** удаагийн хортой код, вирусээс урьдчилан сэргийлж нээхээс нь өмнө устгаж арилгах арга хэмжээ авч ажилласан байна.

2.1.27. Шүүх хуралдааны тэмдэглэлийг хөтлөхөд мэдээллийн технологийн дэвшилтэт программ хангамжийг ашиглах ажлын хүрээнд Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт “Chimege Protocol” сургалт орж, хэрхэн тэмдэглэлээ бичих талаар зааварчилгаа өгч ажиллалаа.



<u>Тамгын газар архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:</u>

2.1.28. Тайлант хугацаанд 3 иргэдээс тамгын газарт гомдол ирүүлсэн бөгөөд 1 гомдлыг Тосонцэнгэл суман дахь Цагдаагийн хэлтэст, 1 гомдлын хариуг тухайн иргэнд өөрт нь, 1 гомдлыг тус шүүх дэх ёс зүйн дэд хороонд шилжүүлж ажилласныг тухай бүрд нь хэрхэн шийдвэрлэсэн талаар Ерөнхий шүүгчид танилцуулж ажилласан.



Д/д	Өргөдөл, гомдол гаргагчийн нэр	Өргөдөл, гомдол гаргасан он, сар	Өргөдөл, гомдол гаргасан хүний нэр, гарын үсэг	Хэзээ, хэрхэн шийдвэрлэсэн	Шийдвэрлэсэн хүний нэр, гарын үсэг
1.	Ж. Эрдэнэчулуун	2024.04.10	С. Ганцоодоржийн өрөө сурвалжлуулах гомдол	Тосонцэнгэл Цагдаагийн хэлтэст 2024.04.15 өдөр тот хүргүүлсэн	Ж. Энхцэцэг
2.	Ж. Баярсаа	2024.04.11	Иргэний хөрөнгө шилжүүлэх зуучлал хүсэлт.	Өөрт нь 2024.04.15 өдөр тот хүргүүлсэн	Ж. Энхцэцэг
3.	Ц. Урнасан	2024.07.24	Ёс зүйн зөрчил гаргасан эрхэм шалгуулах	Ёс зүй хороонд хүргүүлсэн. 2024.07.24	Ж. Энхцэцэг



2.1.29. Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2.2.5.1.-д заасны дагуу Шүүхийн цахим tosontsengel_tg@shuukh.mn хаягаар 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүртэл Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу тухай бүр хэрэгжилтийг хангаж холбогдох байгууллага, иргэн, албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа. Үүнд: тайлан мэдээ, хууль тогтоомж, дүрэм журамд санал авахтай холбоотой 24 албан бичиг, судалгаа авахтай холбоотой 38 албан бичиг, мэдээлэл ирүүлсэн 26 албан бичиг, мэдээлэл авсан 32 албан бичиг, зөвлөмж чиглэл ирүүлсэн 27 албан бичиг, сургалттай холбоотой 20 албан бичиг, бусад байгууллага, иргэд, хуулийн этгээдээс 103 албан бичиг, Улсын дээд шүүхээс мэдээлэл ирүүлсэн 8 албан бичиг, судалгаа авахтай холбоотой 10 албан бичиг, мэдээлэл ирүүлсэн 4 албан бичиг, Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Цагдаагийн хэлтсээс ирүүлсэн 64 албан бичгүүдийг хугацаа хоцрогдолгүй хүлээн авч, хариуг хугацаанд нь гаргаж хүргүүлэн ажилласан. Мөн тус шүүхийн ерөнхий шүүгчид сар бүр танилцуулсан байна.

2.1.30. ШЕЗ болон Монгол шуудан ХК-ний хамтран шуудангийн гэрээний дагуу шүүхийн шуудангийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулан битүүмжилсэн тусгай зориулалтын богц бүхий шууданг хүлээлгэн өгч шуудангийн сүлжээгээр дамжуулан холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэх, гардуулах үйлчилгээг үзүүлж байна. Тайлант хугацаанд нийт **3825** эрх зүйн акт, албан бичгийг шууданд хүргэж ажилласан байна.



ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Баримт бичиг нягтлан шалгах комисс шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Шүүхийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 87 дугаар зүйлийн 87.1.5, 87.2, Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2019 оны 41, А/03, А/19 тоот захирамж, тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн архивын дэргэд баримт бичиг нягтлан шалгах комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Б.Баттуяа /Мэдээлэл технологийн мэргэжилтэн/
Гишүүд: Б.Алтансолонго /Эдэлбэрийн ажилтан/
Н.Энхцацаг /Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн/
Н.Гүнчимэгэн /Дүүх хуралдааны нарийн бичгийн дарга/

Нарийн бичгийн дарга: Б.Баттөр /Архив бичиг хэргийн эрхлэгч/

2. Баримт бичиг нягтлан шалгах комисс нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж батлуулж, шүүхийн архивын баримтад хяналт шинжилгээ хийж илрэхэн зөрчлийг арилгуулах тухай бүр мөлтөх хугацаар танилцуулж, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан, 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 58 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан, хэмжээт өөрчлөлт оруулсан "Шүүхийн архивын ажилтан хуваг"-ыг мөрдөж ажиллахыг чиглэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 06 дугаар сарын 03-ний өдрийн "Баримт бичиг нягтлан шалгах комисс шинэчлэн байгуулах тухай" А/13 тоот тушаалыг хүчингүй болгосуг гэсэн.

ДАРГА Б.БЕЛЭГЗАЙ

Б.Б.Белэгзай

2023 01 02

2.1.31. Тамгын газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/05 дугаартай тушаалаар баримт бичиг нягтлан шалгах комиссыг шинэчлэн баталсан байна. 2024 онд хийсэн хуралдаанаар хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлуулахаар, 2023 оны хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтад заасны дагуу баримт материалуудыг архивт орсон эсэхийг шалгахаар, Завхан аймгийн Прокурорын газарт шилжүүлэх 2023 оны эрүү, зөрчлийн хэргийг данс бүртгэлийг Эрүүгийн хэргийн тусгай архивын дэргэдэх баримт нягтлан шалгах комиссоор батлуулахаар, Шүүхийн тамгын газрын салбар архивт хадгалах хугацаа дууссан иргэний хэргийн жагсаалтыг шүүхийн тусгай архивын БНШАЗК-ын хурлаар

батлуулахаар, Шүүхийн архивд хийсэн тооллогын хүрээнд дутсан 49 хадгаламж нэгжийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн тусгай архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хянан хэлэлцүүлэхээр хүргүүлэхээр, Шүүхийн тусгай архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн №01 дүгээр хурлаар хэлэлцэж батлагдаж ирсэн зөвлөмжийн дагуу устгах иргэний хэргийг дахин нягтлан шалгахаар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн тусгай архивын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 1/3684 дугаартай зөвлөмжийн дагуу иргэний хэргийг устгах асуудлуудаар нийт 7 удаа хуралдсан байна.

2.1.32. 2024.07.28-07.30-ны өдрүүдэд Улсын ерөнхий прокурорын газрын Эрүүгийн тусгай архивд 2022-2023 оны байнга хадгалах 21 хадгаламжийн нэгж буюу 10 эрүүгийн хэргийг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна.

2.1.33. Завхан аймгийн Прокурорын газарт шилжүүлэх 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн №03 дугаар хурлаар хэлэлцэж батлагдаж ирсэн данс бүртгэлийн дагуу Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхээр шийдвэрлэсэн 2017-2023 оны түр хадгалах эрүүгийн хэрэг 425 хадгаламж нэгж, 2017-2023 оны зөрчлийн хэрэг 1287 хадгаламж нэгж, 1984-2023 оны шийтгэх тогтоолын өнгөн хувь 45 хадгаламж нэгж, 2023 оны шийтгэврийн өнгөн хувь 3 хадгаламж нэгж, 2023 оны зөрчлийн шүүгчийн захирамжийн өнгөн хувь 2 хадгаламж нэгж, 2023 оны ерөнхий шүүгчийн захирамжийн өнгөн хувь 1 хадгаламж нэгж нийт 1763 хадгаламж нэгж бүхий хэргийг Завхан аймгийн Прокурорын газарт 2024.11.13-2024.11.14-ний өдрүүдэд шилжүүлж хүлээлгэн өгч ажилласан.


work › SHARE-PC › Users › Public › BATKHUU › Цахим архив › Цахим архив

Name	Date modified	Type
ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ	12/25/2010 12:37 AM	File folder
Зөвлөгөөний тогтоол 2022	2/2/2023 4:31 PM	File folder
Иргэний хэрэг 2003 он	5/10/2011 9:45 AM	File folder
Иргэний хэрэг 2004 он	1/6/2011 9:32 AM	File folder
Иргэний хэрэг 2005 он	11/17/2010 11:28 AM	File folder
Иргэний хэрэг 2006 он	12/21/2010 7:06 AM	File folder
Иргэний хэрэг 2007 он	3/18/2011 7:26 AM	File folder
Иргэний хэрэг 2008 он	6/20/2010 10:26 PM	File folder
Иргэний хэрэг 2009 он	12/2/2010 5:00 AM	File folder
Иргэний хэрэг 2010 он	3/19/2011 3:01 AM	File folder
Иргэний хэрэг 2011 он	12/21/2010 7:24 AM	File folder
Иргэний хэрэг 2012 он	12/1/2010 7:30 AM	File folder
Иргэний хэрэг 2013 он	12/3/2010 2:11 AM	File folder
Иргэний хэрэг 2014 он	12/3/2010 2:04 AM	File folder

2.1.34. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эрх олгосны дагуу Архивын цахимжуулалт хариуцсан гэрээт ажилтныг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуусталх хугацаанд ажиллуулсан бөгөөд 1987-2023 оны шийтгэх тогтоолын өнгөн хувь, 2006-2023 оны шийтгэврийн өнгөн хувь, 1966-2023 оны шийдвэрийн

өнгөн хувь, 1978-2023 оны тамгын даргын тушаал, 2004-2022 эрүү, иргэний хэргийн гар бүртгэл, 2003-2022 иргэний хэрэг цааш нь зах, г/х, е/шз зэргийг цахим хэлбэрт шилжүүлж тайлант хугацаанд нийт 8,695 хэргийг цахим болгоод байна. Тус шүүхийн архивын хадгаламж нэгж бүрэн цахимжсан болно.

2.1.35. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Тусгай архиваар хэлэлцүүлэхээр устгах хэргийн жагсаалт үйлдэн хүргүүлсний дагуу Шүүхийн тусгай архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн №01 дүгээр хурлаар хэлэлцэж, хадгалах хугацаа дуусан, эрх зүй, түүх, эрдэм шинжилгээний болон практикт ач холбогдолгүй болсон 2003 оны 191 хадгаламж нэгж, 2004 оны 205 хадгаламж нэгж, 2006 оны 213 хадгаламж нэгж, 2007 оны 235 хадгаламж нэгж, 2008 оны 259 хадгаламж нэгж, 2009 оны 272 хадгаламж нэгж, 2010 оны 254 хадгаламж нэгж, 2011 оны 179 хадгаламж нэгж, 2012 оны 155 хадгаламж нэгж, 2013 оны 326 хадгаламж нэгж, 2014 оны 267 хадгаламж нэгж, 2015 оны 222 хадгаламж нэгж, 2016 оны 220 хадгаламж нэгж, 2017 оны 230 хадгаламж нэгж, нийт 3228 хадгаламж нэгж бүхий иргэний хэргийг тамгын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/23 дугаартай тушаалын дагуу 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр устгаж ажиллалаа.

2.1.36. Тус шүүхийн архивт хадгалах хугацаа дуусан 2012-2019 оны нийт 988 материал, зөрчлийн хэргийг Эрүүгийн хэргийн тусгай архиваар 2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 017 дугаартай албан бичгээр батлагдаж ирүүлсний дагуу Тус шүүхийн тамгын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/08 дугаартай тушаалаар хадгалах хугацаа дуусан зөрчлийн хэргийг устгасан байна.

2.1.37. Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 2.3.4."архивын баримтыг зориулалтын байр, тавиур, шүүгээнд холбогдох журам, стандартын дагуу хадгалах нөхцөл бүрдүүлэх" гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс өгсөн "Нягтаршуулсан шүүгээ", Архивын өрөөнд 10 метрийн урттай 17 ширхэг ил тавиур зэргийг байршуулсан. Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 6.14.4."тавиурын тавцан хоорондын зай нь хадгаламжийн нэгжийн

өндрөөс 10 см-ээр илүү, 6.14.5.тавиурын доод тавцангаас шал хүртэлх зай 30 см-ээс доошгүй байх" гэж заасны дагуу тавиуруудыг байршуулаад байна.

<u>Тамгын газар шүүхийн бие даасан байдлыг хангах бусад чиглэлээр:</u>

2.1.38. Шүүхээр үйлчлүүлэх орчин нөхцөлийг сайжруулж иргэдэд үйлчлэх хэсгийг өөрсдийн дотоод нөөц боломжоор завсарлаж, шүүхэд мэдүүлэх эрхийг нь тав тухтай орчинд хүргэхээр хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн завсарлалаа.



2.1.39. Ерөнхий шүүгч, шүүгч, шүүхийн захиргааны ажлтнуудын өрөө, 1, 2 давхрын хэсгийн нийт 870 м/кв талбайд эмульс будаг хийж, ажиллах нөхцөлийг тав тухтай болгон сайжруулж, өрөөний цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгүүллээ.



2.1.40. Тус шүүхийн байрны орох хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэдэд зохиулсан налуу замыг стандартад нийцүүлэн хийсэн бөгөөд үүдний хэсгийн дэлгэцээс холбогдох мэдээллийг сонсох боломжтой чихэвч, нэхэмжлэлийн загварыг томруулж харах боломжтой харааны шил болон линз, сонсголын аппарат байршуулж, шүүхийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

2.1.41. Эрүү, зөрчлийн хэргийн эд мөрийн баримтыг яллах дүгнэлтэд тусгагдсаны дагуу нэг бүрчлэн хүлээж авч, гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 81 эрүүгийн хэргийн 65 эд мөрийн баримтыг хүлээн авч хэрэгт дагалдан ирсэн тоног хэрэгсэл, төхөөрөмжийн хэвийн ажиллагаатай эсэхийг нэг бүрчлэн шалгаж, мэдээлэл лавлагааны хэсэгт байрлах камерын бичлэгээр баталгаажуулж хүлээн авсан байна.

2.1.42. Эд мөрийн баримт устгах орон тооны бус комисс нь 2024.04.15-ны өдрийн А/07 дугаартай тушаалаар шинэчлэгдэж, нийт 8 удаа хуралдаж комиссын гишүүдэд мэдээлэл сонсгож, шаардлагатай арга хэмжээг авсан байна. Үүнд: давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хянагдаж ирсэн болон 2022, 2023 оны эрүүгийн 14 хэргийн 54, зөрчлийн хэргийн 4 хэргийн 4, нийт 58 ширхэг эд зүйлийг устгах явцын гэрэл зураг, дуу, дүрсний бичлэгээр бэхжүүлж, бичгээр тэмдэглэл үйлдэж, акт 2 хувь үйлдэж хэрэгт 1 хувийг 1 хувийг байгууллагын хадгаламж нэгж болгон архивд хүлээлгэн өгсөн болно.

2.1.43. Тус шүүхийн тамгын газрын даргын 2024.04.22-ны өдрийн А/12 дугаартай “Гамшгаас хамгаалах орон тооны бус анги байгуулах тухай” тушаалыг шинэчилж, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын төлөвлөгөөг Онцгой байдлын хэлтэстэй хамтран 2024.04.22-ны өдөр баталсан байна. Тайлант хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тохиолдол гараагүй бөгөөд шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэн шүүхийн үйлчилгээг хүргэх, шүүхийн байранд аюулгүй байдлыг хангах, хамгаалах арга хэмжээг өдөр тутамдаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн тус шүүхийн байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг 2024.10.01-2026.10.01-ний өдрийг хүртэл 2 жилийн хугацаагаар, гал унтраах шуурхай төлөвлөгөөг гаргуулан ажилласан.

2.1.44. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн хууль тогтоомж, дүрэм журам, аргачлал, стандартуудаар нэгдсэн сан бүрдүүлж шүүгч, шүүхийн захиргааны ажилтан албан хаагч нарт тухай бүр танилцуулан гарын үсэг зуруулан ажиллаж байгаа бөгөөд шүүхийн захиргааны ажилтан бүр өөрийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх хууль тогтоомж, дүрэм журмыг цаасан болон цахим хэлбэрээр гарган авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан “Эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал”-д 4.4.2-т заасан асуудлыг бид нэмэлт өөрчлөлтөд тусгагдсан дагуу хүлээн авч шийдвэрлэж байгаа бөгөөд харин албан хаагчийг хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажиллуулах, мөн ажлын бус цагаар ажиллуулсан болон бүх нийтийн амралтын өдрөөр ажилласан цалин хөлсийг тооцон олгуулах, аргачлалын 4.4.1-т нэмэлт өөрчлөлтөөр төлөвлөсөн зөрчлийн хэргийг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт хүлээн авах гэсэн агуулга бүхий саналыг дэмжихгүй байна. Учир нь шүүхийн захиргааны ажилтнууд Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд "Долоо хоногийн ердийн ажлын цаг 40 өөс илүүгүй байна..., ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цагаас илүүгүй байна..." гэж хуульчилсан. Гэтэл нь зөрчлийн хэрэг маргааныг шөнийн цагаас бусад цагт хүлээн авна гэсэн нэмэлт өөрчлөлт нь шүүхийн захиргааны ажилтны хуульд заасан ажлын цагийг ноцтой зөрчиж, амрах болон гэр бүлийн ахуй амьдралаа зохицуулах боломж бололцоо нь хааж боогдуулсан асуудал болох юм. Ер нь Монголын улсын шүүхийн захиргаанд ажиллаж байгаа, шүүгчийн туслах болон мэдээлэл лавлагааны мэргэжилтэн ажлын цаг хэтрүүлэн ажилдаг, ажлын ачаалал өндөр байдаг нөхцөлийг харгалзан үзэх нь зүйтэй байна. Хэрэв шүүхийн захиргааны ажилтан ажлаа тараад гэртээ харьсан, эсхүл өөр газар руу явсан тохиолдолд буцаж ирж зөрчлийн хэрэг хүлээн авах нь бэрхшээлтэй хүндрэлтэй асуудал юм. Мөн хот суурин газрын замын хөдөлгөөний түгжрэл зэрэг нөхцөл байдлыг маш сайн харгалзан үзэх хэрэгтэй. Хэрэв шөнийн цагаас бусад зөрчлийн хэргийг авахаар нэмэлт өөрчлөлт оруулахаар бол ээлжийн ажилтантай байхаар нь шийдвэрлүүлэх, уг нэмэлт өөрчлөлт нь шүүхийн практикт хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд харин шүүгч өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай байх хугацаанд ерөнхий шүүгч болон ерөнхий шүүгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч шийдвэрлэх агуулгаар өөрчлөлт оруулах гэж 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр саналыг хүргүүлсэн,

Тамгын газрын “Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусгуулах санал”-д Мэдээллийн технологийн мэргэжилтний АТТ нэмэгдүүлэх санал: 1.2 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн системд эрхийн актын дугаар авч байгаа байдалд өдөр тутам хяналт тавьж, шүүгчийн туслахуудаас гаргасан хүсэлтийг Тамгын газрын даргад танилцуулж алдааг засварлах арга хэмжээ авах; гэсэн хэсэгт ШХНБД, МЛМ, ЭЗ нараас гаргасан хүсэлтийг гэж, Шүүхийн шийдвэрийн санг өдөр бүр тогтмол хянах, хэвийн үйл ажиллагааг хангах, хэрэглэгчийн эрх нээх, хаах, программд тохируулга хийх гэж,

ШХНБД-ын АТТ нэмэгдүүлэх санал: Шүүн таслах ажиллагааны мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр гаргах; гэж нэмэгдүүлэх гэж Шүүхийн ерөнхий зөвлөлд 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 02/165 дугаартай албан бичгээр,

Эвлэрүүлэн зуучлалын улирал тутамд гаргадаг мэдээний маягт, Эрүүгийн мэдээний маягтын төсөлд 3-ШСЭ-2 хохирогчийн мэдээний маягтад 3-ШСЭ-2 хохирогчийн мэдээний маягтаас:

Хүчирхлийн үргэлжилсэн хугацаа, давтамжийг хасах. Мөн мэдээний агуулга тус бүрд гэмт хэргийн ангилал, эмэгтэй, өсвөр насны ангиллыг ялгаж бичих хүндрэлтэй байдаг ба тус бүрд нь гэмт хэргийн хөнгөн, хүндийг ялгах шаардлагатай байдаг. Түүнчлэн хохирогчийн мэдээг нэгтгэж гаргахад олон хохирогч нартай хэрэгт хохирогч тус бүрийг мэдүүлгийг хэргээс биеийн байцаалтыг түүж бичихэд хүндрэлтэй асуудал үүсдэг.

1. *Эвлэрүүлэн зуучлалын мэдээний маягтын төсөлд дараах саналыг гаргаж байна*.
1. Шинээр нэмж ирсэн гэдэгт /4+20+25/ буюу
   - Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд гаргасан өргөдөл
   - Шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлж ирсэн нэхэмжлэл
   - Шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлж ирсэн нэхэмжлэл 3-ын тоо хамт байвал. Ингэснээр нийт эвлэрүүлэн зуучлалд ирж байгаа өргөдөл, нэхэмжлэлийн нийт тоо харагдах болов уу гэсэн санал байна.
2. Иргэн 2014 программд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулахаас татгалзсан үндэслэл дотор өргөдөл гаргагч өргөдлөө татаж авсан гэсэн цэс байдаг. Жич: Миний хувьд уригдагч тал эвлэрүүлэн зуучлалд ирэхээсээ өмнө өргөдөл гаргагчийн өргөдлийн шаардлагыг биелүүлсэн үед өргөдөл гаргагч өргөдлөө буцааж авах хүсэлтээ бичээд өргөдлөө буцааж авсан тохиолдолд үүгээр татгалздаг. Гэтэл мэдээний хүснэгт буцаасан гэж тусдаа мөр байдаг. Энэ асуудлыг нэр мөр болгох санал байна. /программд өөрчлөлт хийх болов уу/
3. Мөн Иргэн 2014 программд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулахаас татгалзсан үндэслэл дотор бусад гэсэн цэс байдаг. Миний хувьд уригдагч талыг удаа дараа дуудаад ирээгүй тохиолдолд ЭЗТХ-ийн 14.2 зүйл, ЭЗА-ы журмын 8 дугаар зүйлийн 8.1.6-д зааснаар эвлэрүүлэн зуучлал хэрэглэхээс татгалздаг. Татгалзсан үндэслэлд бусад гэсэн цэс оруулах санал байна.
4. Мөн Эвлэрүүлэн зуучлалд өргөдлийг хүлээн авахаас татгалзах /ЭЗТХ-ийн 6.1/, эвлэрүүлэн зуучлал хэрэглэхээс татгалзах /ЭЗТХ-ийн 14.2.1, ЭЗАЖ-ын 8 зүйл/ гэсэн хоёр ойлголтыг ялгаж оруулах гэж тус тус саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 02/178 дугаартай албан бичгээр,

Тус шүүх нь “Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх” ажиллагааг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд уг ажиллагааг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлтэй холбоотой дараах саналыг хүргүүлж байна. Үүнд: Тус шүүх нь тойргийн 9 сумдыг харьяалан ажилладаг. Тухайн харьяалах сумдын иргэд ихэнх нь хөдөөний малчин иргэд байдаг бөгөөд иргэний

хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар бүлгийн тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 74.2, 75.3-т үндэсний цахим шуудангийн хаяг болон хувь хүний өөрийн цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийг гардуулна гэж заасныг тухайн орон нутагт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж байна. Учир нь сумдын иргэд /малчин/ үндэсний цахим шуудангийн хаяг, мэйл хаягийг хэрэглэж мэдэхгүй мөн мэйл хаяг байдаггүйгээс болж нэхэмжлэлийн хувь гардуулах, мэдэгдэх хуудас хүргүүлэх ажиллагаанд хүндрэл гарч байна гэж,

““ЧИМЭГЭ” системийг хөгжүүлэх, ажлын байрны ачааллыг бууруулах санал”-д шүүх хуралдааны нарийн бичгийн орон тоог нэмэгдүүлэх, шүүх хуралдааны танхимд байршсан микрофонуудын тоог нэмэгдүүлэх гэж,

"Шүүхийн захиргааны байгууллагад цахим шуудан ашиглан баримт бичиг илгээх, хүлээн авах журам"-ын 3.2-т “Албаны цахим шууданг нууцад хамаарах бол нууцын ажилтан, бусад тохиолдолд эзэмшигч ашиглана.” гэж, 5.1-т заасан эзэмшигч ажлаасаа чөлөөлөгдсөн тухай мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, шүүхийн Тамгын газрын дарга даруй мэдэгдмэгц Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллийн технологийн чиг үүрэг хариуцсан албаны нэгж цахим шуудангийн хаягийг хаана. гэж, 7.1.6 “Өөрийн эзэмшиж байгаа албаны цахим шууданг бусдад ашиглуулах” гэж тус тус санал хүргүүлсэн байна.

ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тайлант хугацаанд буюу 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хүртэл хугацаанд тус шүүхийн бие даасан байдлыг хангах хүрээнд тухайн шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудтай хамтран олон ажил, арга хэмжээг амжилттай зохион байгуулж ажилласан.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2024 онд дэвшүүлсэн зорилго, зорилтын дагуу “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх” зорилгоор иргэд олон нийтэд чиглэсэн, шүүхээр үйлчлүүлж буй иргэд ил тод, нээлттэй, түргэн шуурхай үйлчилгээг хүргэж ажиллалаа.

2024 онд шүүн таслах ажиллагаа буюу системд гаргасан алдаа зөрчлийг арилгах, дахин давтан гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлж дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж ажилласан нь үр дүнгээ өгч 2024 онд хэргийн хөдөлгөөний цахим хяналт, шалгалтаар хагас жилийн байдлаар алдаа, зөрчил өссөн үзүүлэлттэй байсан хэдий ч 2024 оны 3 дугаар улирлын байдлаар буурсан үзүүлэлттэй байна.

2.2. ШҮҮХИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ УДИРДАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2.2.1. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан орон тооны хязгаарт багтаан Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2019 оны 01/1017 тоотын дагуу нийт 17 албан хаагч, 2 шүүгчтэй ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй албан хаагч байхгүй бөгөөд түр тушаалтай ажиллаж байгаа албан хаагч байхгүй. Тус шүүх нь өвлийн цагт уурын зуухаар халаалтаа шийдвэрлэдэг бөгөөд 3 галч ажиллаж байгаа нь хуульд нийцэхгүй байгаа тул

Шүүхийн ерөнхий зөвлөлд хүсэлт гаргасны дагуу нэг галчийг ажил гүйцэтгэх гэрээгээр галлагаа зогсох хүртэл ажиллуулах зөвшөөрөл олгосон учир гэрээт ажилтныг оруулаад нийт 18 орон тоотой ажиллаж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024.09.18-ны өдрийн 206 дугаар тогтоолоор тамгын газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шинээр нэмэгдэж буй орон тоонд ажиллуулах хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ДООД ХЯЗГААР

№	Албан тушаалын нэр	Орон тооны хязгаар
1	Шүүхийн Тамгын газрын дарга	1
2	Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн	1
3	Шүүгчийн туслах	4
4	Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга	3
5	Бичиг хэрэгч	1
6	Хүний нөөц, дотоод ажил хариуцсан шинжээч	1
7	Олон нийтэй харилцах мэргэжилтэн	1
8	Мэдээллийн технологийн мэргэжилтэн	1
9	Мэдээллийн технологийн инженер	1
10	Эмэгтэйчүүд хүчирхэг	1
11	Эмэгтэйчүүд хүчирхэгт туслах ажилтан	1
12	Аялах нягтлан бодогч	1
13	Архивч	1
14	Бичиг хэргийн эрхлэгч	1
15	Нярав	1
16	Энч	1
17	Сэргэл зүйч	1
18	Төрийн үйлчилгээний бүсэд гүйцэтгэх ажилтан (Жолооч, мужаан, слесарь, цахилгаанчин, үйлчлэгч, гаалч бүсэд)	6
	Нийт	28

2.2.2. Шүүхийн захиргааны ажилтнуудын хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын хүрээнд “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-д заасны дагуу хувийн хэргийг

хөтөлж, хувийн хэргийн бүрдлийг тусгайлан хуудас бүрээр хийж бэлтгэн шинэ хавтаст хийж хадгалж байна. 2024 онд нийт 19 албан хаагч төрийн албан хаагчийн хувийн хэргээ журамд заасны дагуу шинэчилсэн бөгөөд хувийн хэргийг тусгайлсан сейфэнд нууцын журмын дагуу хадгалж, хамгаалалтыг хариуцан ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын 02-ны байдлаа нийт шүүхийн захиргааны 7 ажилтны, үйлчилгээний 12 ажилтны хувийн хэргийг хадгалж байна.

2.2.3. Тус шүүхийн тамгын газрын дарга шүүхийн захиргааны ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт болон 2024 оны шүүхийн тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан Төрийн захиргааны 6 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төрийн үйлчилгээний 11 ажилтны үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан баталгаажуулж, биелэлтийн явцын ярилцлагыг 1, 3 дугаар улирал, хагас бүтэн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 20-ны дотор хийж, үнэлгээг баталгаажуулж байна.



Засгийн газрын Хяналт эрхлэх газрын даргын 2023 оны 90 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ШУТГЫНХИЙН ТУСЛАХ Б.ЭНХРИЙМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүлээх түвшин: Эхний хагас жил	Хүлээх түвшин: Сүүлийн хагас жил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	2		3	4	5	6	7
НЭГ. "Шүүхийн шүүн таслах ажиллагаанд хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх аюулыг тасралтгүй зохион байгуулах " ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ №1.1. Эрүүгийн хэрэг, Иргэний хэрэг, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүү, иргэний хэрэгт хэдлэгдэнэ нийтлэг арга-нарын дагуу гүйцэтгэх.	Ажиллагаа явсан эрүүгийн хэрэг, иргэний хэрэг, зөрчлийн хэргийн тоогоор /0-100 хувь хүртэл /	Эрүүгийн хэргийн шүүгчийн захирамж-78, шийтгэх тогтоол-22, зөрчлийн хэргийн шүүгчийн захирамж-131, шийтгэвэр-96, иргэний хэргийн шүүгчийн захирамж-364, шүүхийн шийдвэр-80, гуйцэтгэх хуудас-35, тус тус Иргэн-2014 болон Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем дэх хуулбаны хоцрогдолгүй хуулж ажилласан байна.	50%	100%	01 дүгээр сарын 02 өдөр	12 дугаар сарын 31-ний өдөр
2.	Арга хэмжээ №1.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэвийн тасралтгүй, тулгын шүүгчий зохион байгуулах.	Хэргийн хөдлөлөөнийг арга-нарын дагуу аудав зөрчлүүд зохион байгуулна.	/0-100 хувь хүртэл /	Эрүүгийн хэргийн шүүгчийн захирамж-78, шийтгэх тогтоол-22, зөрчлийн хэргийн шүүгчийн захирамж-131, шийтгэвэр-96, иргэний хэргийн шүүгчийн захирамж-364, шүүхийн шийдвэр-80, гуйцэтгэх хуудас-35, тус тус Иргэн-2014 болон Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын	50%	100%	01 дүгээр сарын 02 өдөр	12 дугаар сарын 31-ний өдөр

2.2.4. Шүүхийн тамгын газарт Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын сул орон тоо гарсан бөгөөд төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлж, тусгай шалгалтад тэнцсэн

Б.Батбаярыг мэдээлэл лавлагааны мэргэжилтний албан тушаалд 2024.12.02-ны өдрөөс эхлэн томилон ажиллуулж байна. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгын албан бичгийг 2024.09.13-ны өдөр хүний нөөцийн хүргүүлсэн одоогоор тусгай шалгалт зарлагдаагүй байна.

2.2.5. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хүрээнд 7 хоног бүрийн 4 дэх өдөр спорт зааланд сагсан бөмбөг, гар бөмбөг тоглох цаг авч байгаа бөгөөд хуваарьт хугацаанд хөгжөөнт цэнгээнт уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулж байна.

Тус шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд өөрсдийн хуримтлалаар дартсын самбар худалдсан авсан. Хөдөлмөрийн явцад бий болсон ядралыг сэргээх, хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор дартсын спортоор хичээллэж байна.

2.2.6. 2024.06.20-ны өдөр сумын “Мөнхийн алба” өрхийн эмнэлэгтэй хамтран сахар, элэгний В, С вирусийн шинжилгээ болон биеийн индексийн үзлэгт хамруулсан байна.

2.2.7. Тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагддаг “Тусгай алба 2024” урлаг спортын наадамд оролцсон. Мөн тус наадмын үеэр шүүхийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулахад оролцсон.

2.2.8. 2024.01.12-ны 02/09 дугаартай албан бичгээр шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудыг салбарын болон төрийн дээд одон медальд тодорхойлж материалыг хүргүүлсэн байна. Үүнээс: 2024.07.08-ны өдөр Мэдээлэл технологийн мэргэжилтэн Б.Баттулга, нярав Н.Болдбаатар нар Хууль зүй, дотоод хэргийн яамны “ЖУУХ БИЧИГ”, галч Л.Дэмидбалдан Шүүхийн ерөнхий зөвлөлийн “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ээр тус тус шагнагдсаныг гардуулсан байна.

2.2.9. Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн галч Л.Очирбатад “СУМЫН АЛДАРТ УЯАЧ”-ийн малгайг Тосонцэнгэл сумын “ТОСОН ШАНДАС” уяачдын холбооны тэргүүн О.Энхжаргал гардуулан өгсөн байна.

2.2.10. Тайлант хугацаанд шүүгч нар Завхан аймаг бүрэлдэхүүнд 1 шүүгч 1 удаа, Архангай аймагт 2 шүүгч 1 удаа сургалтад, 1 шүүгч 2 удаа тойргийн суманд очиж даалгавар гүйцэтгэх ажиллагаа явуулсан. 1 шүүгч 1 удаа тамгын газрын даргын албан үүргийг түр орон гүйцэтгэгч, мэдээлэл технологийн мэргэжилтэн, ахлах нягтлан бодогч, эвлэрүүлэн зуучлагч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар, нярав, жолооч, болон мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, эвлэрүүлэн зуучлагчийн туслах гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг “Нээлттэй шүүх өдөрлөг” арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаатай тойргийн 6 суманд, тамгын газрын даргын албан үүргийг түр орон гүйцэтгэгч, нягтлан бодогч, нярав нарын хамт Улаанбаатар хотод 1 удаа, архив бичгийн эрхлэгч, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, бичиг хүргэгч, жолооч Завхан аймагт 1 удаа, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, бичиг хүргэгч ахлах нягтлан бодогч нар Завхан аймагт 1 удаа, мэдээлэл технологийн мэргэжилтэн Улаанбаатар хотод 1 удаа, эвлэрүүлэн зуучлагчийн туслах Улаанбаатар хотод 1 удаа, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах,

жолооч тойргийн сумдаар 1 удаа ажилласан бөгөөд томилолтын зардлыг шүүхийн төсвөөс тухай бүр олгож ажилласан байна.



2.2.11. Монгол Улсын шүүхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шүүгчид 141/ЗТ2023/00005, 141/ЗТ2023/00006, 141/ЗТ2023/00007, 141/ЗТ2023/00012, 141/ЗТ2023/00024, 141/ЗТ2023/00031, 141/ЗТ2023/00052, 141/ЗТ2023/00012 дугаартай шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор 7 удаа чөлөө олгосон бол Шүүхийн захиргааны 17 ажилтанд 1-3 өдрийн цалинтай чөлөөг Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем “ERP” болон чөлөөний хуудсаар, шүүхийн захиргааны ажилтанд тушаалаар 4 удаагийн цалинтай чөлөөг олгосон байна.

2.2.12. Тайлант хугацаанд тус шүүхийн шүүгч нар албан үүргээ гүйцэтгэх явцад бие махбодод гэмтэл, эрүүл мэндэд хохирол учирсан, нас барсан тохиолдолд гараагүй бөгөөд энэ хүрээнд ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй.



ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ
ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Улаанбаатар хот

Урамшуулал олгох тухай

Шүүхийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.5, 87.2, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 52.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.11, 16.5.5, Мөрөн Засагчийн газрын 2003 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 301 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тепелелеег боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, ур дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", Ажлын болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 5.1.11, 9.2.6, Хөдөлмөрийн дотоод журмын 11 дүгээр зүйлийн 11.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААЛ ХӨ:

1. Тус шүүхийн тамгын газрын 2024 оны хагас жилийн гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны тепелелеенний тайлан, ур дүнг үндэслэн эрхэлсэн ажлуудыг ажилтан гарган гүйцэтгэлийн тепелелее болон хөдөлмөрийн гаргалгаар хүлээсэн ажил, үүргээ хангалттай биелүүлсэн шүүхийн захиргааны болон үйлчлүүлэгчий ажилтан албан хаагчдад хөнгөлөлт, шагнал олгох үндэслэл цалингаас ур дүнгийн урамшуулал олгохгүй.

2. Ур дүнгийн урамшуулыг тэсвэгч зохиох зардлаас гаргахыг аймаг дотоодоо /Э.Доржнамжирмаа/-д зөвшөөрсүгэй.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭХ Ш.ЭНХЦЭЦЭГ

2.2.13. Шүүхийн захиргааны ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах, идэвхжүүлэх хүрээнд тэдгээрээс гаргаж буй шинэ санал санаачлагыг дэмжин ажиллаж үр дүнд хүрсэн ажил, арга хэмжээ санаачлан зохион байгуулсан албан хаагчид нэмэлт оноо өгөх, ажлын үр дүн гүйцэтгэлд оруулан тооцож, үр дүнгийн урамшуулал болон ур чадварын нэмэгдэл олгох, шагналд нэр дэвшүүлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. Тайлант шүүхийн захиргааны 3 ажилтаныг салбарын шагналаар шагнаж урамшуулсан бөгөөд 3 ажилтны зэрэг дэвийг нэмэгдүүлэхээр холбогдох материалыг хүргүүлж, 2024 оны эхний хагас жилийн ажлын үр дүнд үндэслэн 16 ажилтанд үр дүнгийн урамшуулал олгож, шүүхийн үйлчилгээний 11 ажилтанд ур чадварын нэмэгдлийг холбогдох дүрэм журмын дагуу 01-11 сар хүртэл олгосон байна.



2.2.14. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байгаа бөгөөд тус шүүхийн захиргааны ажилтнуудын хүйсийн харьцааг 10 эрэгтэй, 11 эмэгтэй ажилтантай бөгөөд хүйсийн харьцааг тэнцвэртэй байх нөхцөлийг хангаж ажиллаж байна. Нийт шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын нэгдсэн хуралдаанаар

"Хөдөлмөрийн дотоод журам"-д өөрчлөлт оруулж жендерийн эрх тэгш байдлыг хангах талаарх ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг тусгасан.



2.2.15. Шүүхийн захиргааны ажилтнуудын ажлын гүйцэтгэл үр дүнд үндэслэн илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах, цаашид дахин давтан гаргуулахгүй байхад онцгой анхаарч заавар, чиглэл өгч, амжилттай сайн ажилласан ажилтнуудыг алдаршуулах, цалин хөлсийг нь нэмэгдүүлэх, үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох зэрэг ажлыг зохион байгуулж байна. 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг үнэлж үндсэн цалингийн 100 хүртэл хувиар үр дүнгийн урамшуулал олгосон. Мөн үйлчилгээний ажилтнуудад 2024 оны 01 дүгээр сараас 12 дугаар сар хүртэл 10-25 хувийн ур чадварын нэмэгдлийг сар бүр олгож ажилласан.

2.2.16. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан журам, аргачлалын дагуу үнэлж дүгнэсэн бөгөөд 2024 оны эхний хагас жилийн байдлаар тус шүүхийн тамгын газрын шүүхийн захиргааны 6, үйлчилгээний 11 албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг аргачлалын дагуу үнэлж, дүгнэж ажилласан. 2024 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг МУ-йн Засгийн газраас шинэчлэн батлсан журам, холбогдох аргачлалын дагуу 12 дугаар сарын 20-ны дотор үнэлж дүгнэхээр төлөвлөж байна.



ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ
ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1, 87.2 дахь заалт, Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 9.6 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм"-ийн 6.1, 6.2 дахь хэсгийн тус тус үндэслэн ТУШААХ Нь:

1. Тус шүүхийн тамгын газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шүүхийн ажилтны ёс зүйн дүрэм болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан хариуцлага хүлээлгэх үүрэг бүхий орон тооны бус "Ёс зүйн зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд дараах байдлаар өөрчлөлт оруулсугай.

Ёс зүйн зөвлөлийн дарга: Н.Гүнчинсүрэн /ШХНБДарга/
Гишүүд: Б.Алтансолонго /Эвлэрүүлэн зуучлагч/
Л.Золбоо /Эвлэрүүлэн зуучлагчийн туслах/

2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг ёс зүйн зөвлөл /Н.Гүнчинсүрэн/-д даалгасугай.

3. Ёс зүйн зөвлөлөөс зохион байгуулж буй ажилд идэвхитэй оролцож, шүүхийн ажилтны ёс зүйн дүрэм, төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтны ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллахыг нийт ажилтан албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГА Б.ӨЛЗИЙ

2.2.17. Шүүхийн тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/01 дугаар тушаалаар даргаар Н.Болдбаатар /нярав/, гишүүд Б.Баттулга /мэдээлэл технологийн мэргэжилтэн, Б.Алтансолонго /эвлэрүүлэн зуучлагч/ нарын бүрэлдэхүүнтэйгээр ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан бөгөөд шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүй, сахилга хариуцлагыг бэхжүүлэх, ажлын цаг ашиглалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч байна. Тайлант хугацаанд тус шүүхийн захиргааны ажилтнуудтай холбоотой 3 өргөдөл, гомдол ирсэн байна. Ёс зүй, сахилга хариуцлага алдсан 1 захиргааны ажилтанд сахилгын шийтгэл хүлээлгэн байна. Ёс зүйн дэд хорооны зүгээс 1 гомдлыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ёс зүйн хороонд шилжүүлж, 1 гомдлыг шалгах хуульд заасан хугацаа хэтэрсэн байх тул гомдлыг буцааж шийдвэрлэсэн байна.

2.2.18. Ёс зүйн дэд хорооноос байгууллагын албан хаагчдад Засгийн газрын 109 тогтоолын хүрээнд “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” “Төрийн албан хаагчдын хувцаслалт” “Хандлага оюун ухаанаас илүү чухал” сэдвүүдээр сургалтууд орж, мөн Хүний эрхийн үндэсний комиссын Завхан аймаг дахь референт Ч.Наранхүүтэй холбогдож байгууллагынхаа захиргааны болон үйлчилгээний ажилтнуудад "Жендэр ба хөдөлмөрийн харилцааны хүрээн дэх хүний эрх", сэдвээр сургалт оруулж, энэ талаар байгууллагын албан ёсны хуудаст мэдээлэл бэлтгэж оруулсан.

2.2.19. Тус шүүхийн тамгын газарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан үйлчлэгч Д.Даваажаргалыг Шинэ жил , Цагаан сарын баяр, Ахмадын баярын өдрүүдээр хүлээн авч, жил бүр хүндэтгэл үзүүлдэг.

2.2.20 Шүүхийн захиргааны ажилтны холбооны татварыг сар бүр бүрэн төлж татварын өглөггүй ажиллаж байна. Нийт 2024 оны бүтэн жилийн татвар болох 408,000 төгрөгийг урьдчилж төлсөн байна.


Гүйлгээний дэлгэрэнгүй

Гүйлгээний мэдээлэл
Дүн: -204,000.00 MNT
Гүйлгээний төрөл: Зарлага
Огноо: 2024.08.19 16:37

Шилжүүлсэн данс
Данс/IBAN: 5495 328 576 MNT
Үлдэгдэл: 375,053.85

Хүлээн авсан данс
Данс: 5027 507 752

Утга
За. Тсонцэнгэл 2,3 улирал татвар

2.2.21. Эвлэрүүлэн зуучлалаас тойргийн сумдад нүүдлэн ажиллахад тамгын газраас ажиллах нөхцөл бололцоогоор хангаж 2024 онд сумдаар томилолтоор 2 удаа ажиллуулсан бөгөөд эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэхэд онцгой анхаарч 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Эвлэрүүлэн зуучлалын зөвлөлөөс зохион байгуулсан “Сингапур болон Монгол дахь Эвлэрүүлэн зуучлалын харьцуулалт” цахим сургалтад хамруулж, шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.

2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хооронд ШЕЗ-өөс “Эвлэрүүлэн зуучлагчийн туслахуудыг мэргэшүүлэх” сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

ГЭРЧИЛГЭЭ

Очирбаатын Оттонжарган-д



“Шүүхийн захиргааны цахим сургалтын систем”-д байршсан Архив, бичиг хэргийн эрхлэгч нарт зориулсан сургалтын хүрээнд Баримт хадгалалт, хамгаалалт, Архивын баримтын хадгалалт, Архивын баримтын ажлын арга зүй, зохион байгуулалт, Эвлэрлийн гэрээ, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудлууд, эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, шүүхийн хэргийн хөдөлгөөний удирдлага, шүүхийн сэтгэл зүй, шүүгчийн харилцаа хандлага, Жендэрийн ойлголт, Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын системд нарийвчилсан журмын тохиргоо хийх тохируулах зааварчилгаа, Шүүн таслах ажиллагааны 2024 оны 1 дүгээр улирлын мэдээ тайлан гаргах заавар, Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем, шүүгчийн туслахууд зориулсан “Нотлох баримт хадгалалт, хамгаалалт”, “Хавтаст хэрэг хүлээн авах”, “Шүүгчийн ёс зүй”, “Захиргааны хэргийн шийдвэр боловсруулах аргачлал”, “Шүүгчийн туслахын үндсэн чиг үүрэг” сургалтуудад шүүхийн захиргааны болон үйлчилгээний ажилтнууд өөрсдийн чиг үүрэг бүхий хичээлүүдийг бүрэн судалсан байна.

2024.11.14-11.18-ны өдрүүдэд Завхан аймагт Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад мэдээлэл лавлагааны мэргэжилтэн Б.Батбаяр, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Батхүү, ахлах нягтлан бодогч Э.Доржналжирмаа нар хамрагдаж гэрчилгээ авсан байна.





Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн пүрэв гаригт цахимаар явуулж байгаа 7:4:10 сургалтад шүүхийн захиргааны ажилтнууд “Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд бүтэц”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн танилцуулга”, "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа", “Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо”, “Төрийн албан хаагчийн хөгжил”-ийн тухай” сэдэвт сургалтуудад тухай бүр хамрагдсан байна.

2.2.22. Шүүхийн хүний нөөцийн программд үүсгэсэн бүртгэлийн мэдээллийг шүүгч, ажилтанд журам заасны дагуу нээснээс хойш ажлын 3 өдрийн дотор танилцуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд шүүгч Ж.Отгонхишигийг Ховд аймгийн шүүхийн тамгын газар, тамгын газрын дарга Б.Өлзийг Хэнтий аймгийн шүүхийн тамгын газар хүргүүлэн ажилласан байна. Одоогоор нийт шүүхийн захиргааны 19 ажилтны мэдээллийг нягтлан шалгаж баталгааны хуудсанд гарын үсэг зуруулан ШЕЗ-д жил бүрийн 6 дугаар сарын 01, 12 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлдэг бөгөөд програм дахь шүүгч, ажилтны бүртгэл, мэдээлэлд тухай бүр баяжилт хийж тухай бүрд, баримт бичгийн хуулбарлан /PDF/ болгон оруулж байна.

ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тайлант хугацаанд шүүхийн хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, мэргэшсэн шүүхийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, бодлого барьж ажилласны үр дүнд Төрийн албаны зөвлөлөөс зарласан ерөнхий шалгалтад 2 ажилтан тэнцсэн, шүүхийн захиргааны 1 ажилтан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зарласан албан тушаалын тусгай шалгалтад тэнцэж төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөж шүүхийн шүүн таслах ажиллагааны нэг хэсэг болон ажиллаж байна.

Мөн шүүхийн хүний нөөцийн программын ашиглалт, нөхөн бүрдүүлэлтэд тухай бүр хяналт тавьж шүүхийн захиргааны 18 ажилтны хувийн хэргийг шинэчлэн гаргуулж, холбогдох мэдээллийг бүрэн гаргуулан авч хадгалалт, хамгаалалтын шинэчлэн ажиллаж байна.

Тус шүүхийн болзол шаардлагыг хангасан шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудыг төрийн болон салбарын шагналаар шагнуулахаар баримт материалыг ШЕЗ-д хүргүүлэн нийт 3 ажилтан салбарын шагналаар шагнагдсан нь шүүхийн захиргааны ажилтнуудын итгэл зүтгэлийг үнэлсэн, цаашид хийх бүтээх хүсэл эрмэлзлийг нэмэгдүүллээ.

2024 онд тус шүүхийн 1 шүүгч Ховд аймаг дахь Давж заалдах шатны шүүх рүү шүүгчээр, тамгын газрын дарга Хэнтий аймаг дахь Шүүхийн тамгын газрын даргаар тус тус шилжин явсан. Тус шүүх нь 2 шүүгч, 18 шүүхийн захиргааны ажилтантай орон тоо дутуу ажиллалаа.

Тус тамгын газрын шүүхийн захиргааны 2 буюу төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагад нь холбогдуулан албан тушаалтан, иргэн өргөдөл, гомдол гаргасан байна. Үүнээс харахад шүүхийн захиргааны ажилтны харилцаа, хандлагыг сайжруулахад анхаарах нь зүйтэй байна.

2.3. Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

Завхан аймгийн Цагдаагийн газрын Тосонцэнгэл сумын сум дундын цагдаагийн хэлтсээс хамгаалалтын цагдаа 1, харуулын цагдаа 4, нийт 5 алба хаагчтайгаар шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах чиг үүргийг гүйцэтгэн ажиллалаа.

2.3.1. Тус шүүхээр эрүүгийн хэргийн 152, иргэний хэргийн 223, зөрчлийн хэргийн 1286, цагдан хорих 22, хянан магадлан 3 нийт 1686 шүүх хурал явагдаж, 4401 оролцогчдод шүүх хуралдааны дэгийг танилцуулж, “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”-д заасны дагуу шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

2.3.2. Тайлант хугацаанд шүүгчид хууль ёсны эрх ашгаа хамгаалахаар шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагад тайлбар, хүсэлт гаргах, нотлох баримт бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс гомдол, хүсэлт тохиолдол байхгүй. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүн, аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ

хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх тохиолдол гараагүй. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд гараагүй тул уг шийдвэр, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалах арга хэмжээг дангаараа болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албатай хамтран хэрэгжүүлэх тохиолдол гаргаагүй.

2.3.3. Тус шүүхийн 3 шүүгчид 2019 онд бие хамгаалах хэрэгсэл “Цахилгаан бороохой” олгосон бөгөөд хэвийн ажиллаж байгаа бөгөөд тухайн бие хамгаалах тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалтад тухай бүр хяналт тавьж, 2024.02.24-ний өдөр Завхан аймгийн Цагдаагийн газрын Тосонцэнгэл сумын сум дундын цагдаагийн хэлтэстэй хамтран шүүгч нарт "Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх, хадгалах" сэдэвт сургалт зохион байгуулж, тусгай хэрэгслийг хэрхэн ашиглах, хамгаалах талаар зааварчилгаа өгсөн.

2.3.4. Тайлант хугацаанд шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл байдал үүсээгүй бөгөөд ямар нэгэн хамгаалалтын арга хэмжээ авч, шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах, хамгаалах чиглэлээр цагдаагийн байгууллага болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажилласан тохиолдол гаргаагүй.

2.3.5. Эрүүгийн 6, зөрчлийн 2, иргэний 3 албадан ирүүлэхээр, иргэний 5 эрэн сурвалжлуулахаар нийт 16 ялтан, шүүгдэгч, яллагдагч, хариуцагч, зөрчилд холбогдогч нарыг албадан ирүүлэх, эрэн сурвалжлуулах шүүгчийн захирамж, шийдвэр гаргаснаас одоогийн байдлаар 14 албадан ирүүлэх, эрэн сурвалжлуулах ажиллагааг бүрэн гүйцэд хийгдсэн байна. 1 ялтанг албадан ирүүлэх, 1 хариуцагчийг эрэн сурвалжилж хаягийг нь тогтоохоор цагдаагийн байгууллага ажиллаж байна.

2.3.6. Зөрчлийн хэргийн шүүх хуралдаанд оролцохоор ирсэн зөрчилд холбогдогчдыг согтуурал хэмжигч багаж үлээлгэн шалгаж, согтууруулах ундаа хэрэглэсэн байсан 4 зөрчилд холбогдогчийг шүүх хурлын танхимд нэвтрүүлэлгүй даргалагч шүүгчид танилцуулан, шүүгчийн захирамжийн дагуу цагдаагийн хэлтсийн саатуулах байранд хүргэж, эрүүгийн хэргийн 2 шүүгдэгчийг хурлын танхимд нэвтрүүлэлгүй албадан гаргаж ажилласан. Мөн зөрчлийн хэргийн шүүх хуралдаанаар шүүхээр баривчлах шийтгэл оногдуулсан 104 этгээдийг цагдаагийн хэлтсийн баривчлах байранд хүргэж, хүлээлгэн өгч ажилласан. Шүүх хуралдааны

дараа шүүгчийн зөвшөөрлөөр яллагдагч, шүүгдэгч, ялтантай тэдний өмгөөлөгч /30/ ар гэрийн гишүүн /14/ уулзах үед харгалзан, хяналт тавьж ажилласан. Тосонцэнгэл сум дахь ШШГХ-ийн цагдан хорих байрнаас шүүх рүү 38 удаа, шүүхээс ШШГХ-н цагдан хорих байр руу 57 удаа яллагдагч, ялтан, шүүгдэгчийг нийт 95 удаа, ердийн журмаар, албаны тээврийн хэрэгслээр, маршрутын дагуу 542 км зам туулж хуяглан хүргэх ажиллагааг гүйцэтгэж ажилласан байна.

БАТЛАВ
ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ ШҮҮХИЙН ХАМТРАН АЖИЛЛАХ ЖИШИГ ТӨЛӨВЛӨГӨӨ
Д.ЭНХБАЯР

БАТЛАВ
ЦАГДАН ХОРИХ БАЙРНЫ ГАЗАРТ ХОРИГДОГСДЫН ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАХ ХЯНАЛТЫН ГАЗАР
Г.ГҮНЧИНБАЯР

ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕД ХАМТРАН АЖИЛЛАХ ЖИШИГ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр Тосонцэнгэл сум

Зорилго: Шүүх төслөх ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх хорихгүйгээр шүүх, шүүхийн тамгын газрын аюулгүй байдлыг хангах, хамгаалах, шүүх хуралдааны ... шүүх, шүүх бүрэлдэхүүн, шүүгчдийн ... ажиллах, ... ажилтнуудыг ... ажилтнуудыг нөхцөлтэй ... шүүхийн ... ажилтнуудыг ... шүүгдэгч, гэрч, хохирогчийн ... ирүүлэх, шүүхийн ... зайлсан ялтнуудыг, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах ажиллагааны явцад онцгой нөхцөл бүйдэл үүссэн үед учрах эрсдэл, аюулыг зайлуулах, хохирлыг багасгах шүүх, шүүхийн Тамгын газрын байрыг хүч хэрэглүүлэн хамгаалагчид, аюул чиглэлээр цагдаагийн байгууллага, шүүхийн тамгын газар хамтран ... хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсод оршино.

Онцгой нөхцөл бүйдэл: Шүүх, шүүхийн Тамгын газрын гадна орчинд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх, гэмтэлтэй хүлээлгэ гарах, шүүгч, гэрч, хохирогчийн ямх бөөц хөөцөх, бөөцөлөгөх, шүүхийн бөөр рүү довтлох, бүслэх, үүл ажиллагаа тасалдуулахыг оролдох, гадаа: цагаан, шүүхийн байрны орчимд зэмсэг хаяглэсэн хавтас зэрэг аливаа хүүгээр бусаар үйлдэлтэй улмаас шүүхийн шүүх тасалж ажиллаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болсон, мөн олны анхаарал татсан, олон үйлдэл, арилжаатай хэрэг, маргааны шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг шүүхийн байранаас бусад газарт хийх зайлшгүй шаардлага.

№	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан
	1.Мэдээлэл солилцох, мэдээлийн нээлттэй хангах		
1.1	Онцгой нөхцөл бүйдэл үүссэн үед ард түмэн цагдаагийн байгууллагад мэдээлэх, хүч хэрэглүүлэхгүй хамгаалах аяны хүсэлтийг хүргүүлэх;	Тухай бүр	Шүүхийн Тамгын газар
1.2	Шүүхийн Тамгын газраас нүүрлэсэн мэдээллийг хүлээн авч, хүч хэрэглүүлэхгүй хамгаалалт аяны хүсэлтийг шуурхай шийдвэрлэх, шүүхийн тамгын газар харуулах мэдээлэх	Тухай бүр	Цагдаагийн байгууллага
1.3	Олны анхаарал татсан, олон үйлдэл, арилжаатай хэрэг, маргаанд шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны нээлттэй байдлыг хангах,	Тухай бүр	Шүүхийн Тамгын газар



ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

9/СОЛ ... Дугаар 8/А/ Тосонцэнгэл сум

Гамшгаас хамгаалах орон тооны бус анги байгуулах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчлэлсэн найруулга/-ийн 87 дугаар зүйлийн 87.1.5, 87.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3, 34.2.4, "Аюулаг болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллаганы нийтлэг журам"-ын 4.6.7-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх, шүүхийн тамгын газрын даргадах "Гамшгаас хамгаалах орон тооны бус анги"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Орон тооны бус анги дарга: Ерөнхий шүүгч Б.Үртнасан
Гишүүд: Шүүгч Б.Бөмбийжаргал
Тамгын газрын даргын албан тушаалтан Н.Энхцацаг
Мэдээлэл технологийн мэргэжилтэн Б.Баттулга
Шүүгчийн туслах Б.Энхриймаа
Шүүх, шүүгчийн аюулгүй байдал хариуцсан хаалгын цагдаа ахлах ахлагч Б.Энхбат
Ахлах нягтлан бодогч Э.Доржнаранжирмаа
Нярав Н.Болдбаатар
Жолоочин Г.Эрдэнэсайхан

2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, аврах гаргах сүүл зургийг шинэчлэн гаргах маргаашийн байгуулагаар хянуулж батлуулаарай Мэдээлэл технологийн мэргэжилтэн /Б.Баттулга/-д, нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр хангах, зарлан мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүлэхийг Нярав Н.Болдбаатар/-г, батлагдсан төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах, баттгаа хангалыг Орон тооны бус анги дарга /Б.Үртнасанд/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг нийт шүүгч, шүүхийн захиргааны ажилтан албан хаагч нарт танилцуулах Архив бичиг хэргийн эрхлэгч /Б.Батхуу/-д даалгасугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ТУШААЛТАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭНХЦЭЦЭГ

2.3.7. Шүүх, шүүхийн байрны гадна орчинд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэсэн, шүүгч, гэрч, хохирогчийн амь биед халдах, барьцаалах, байгалийн аюулт үзэгдэл, осол, гамшиг гарсан тохиолдол гаргаагүй бөгөөд цагдаагийн байгууллагатай “Хамтран ажиллах төлөвлөгөө”, 2024.01.15-ны өдөр, 2024.07.25-ны өдөр “Онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах жишиг төлөвлөгөө”г баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах бэлэн байдлыг хангуулан ажиллаж байна.

2.3.8. Шүүхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд харуулын цагдаа дээр дуудлагын хонх байрлуулсан бөгөөд шүүхийн хаалгаар орж гарч буй тохиолдолд мэдээлэл өгөх хонхыг суурилуулан шүүхийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, онцгой нөхцөлд ажиллах ажилтны нэрсийг 2024.04.22-ны өдрийн А/12 дугаар тушаалаар шинэчлэн баталж шүүхийн харуулын цагдаад өгч, шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд танилцуулан ажилласан байна.

2.3.9. Тус шүүхийн тамгын газар нь шүүхийн барилга байгууламж болон түүний гадна орчинд аюулт үзэгдэл, гамшиг үүссэн үед ажиллах талаар Завхан

аймгийн Тосонцэнгэл сум дахь Онцгой байдлын хэлтэстэй баталсан төлөвлөгөөний дагуу танхимын сургалт болон дадлага сургуулилтыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хийж, бэлэн байдлыг хангаж хамтарч ажиллалаа.

2.3.10. Шүүгчийн хараат бус байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд хандсан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд “Нөлөөллийн мэдүүлэг”, “Шүүгчийн хараат бус байдал”-ын талаар гарын авлагыг шүүхийн цахим болон фэйж хуудсаар, шүүхийн үйлчилгээний хэсэгт мэдээллийн самбарт тус тус байршуулан ажилласан.

2.3.11. Тайлант хугацаанд өөрийн амьдарч байгаа орон байранд галын аюулгүй байдал, гэмт халдлагаас хамгаалагдсан эсэхэд мэргэжлийн байгууллагаар үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулах тухай шүүгч нараас хүсэлт ирүүлээгүй бөгөөд мэргэжлийн байгууллагад хандсан тохиолдол гараагүй.

ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж, шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын аюулгүй байдлыг бүрэн хангуулж, шүүх хуралдааны оролцогч нарт шүүх хуралдааны дэгийг ойлгомжтой байдлаар танилцуулж, шүүгч, шүүх бүрэлдэхүүний шийдвэрийн биелэлтийг хангуулах, шүүхийн тогтоол шийдвэр цаг хугацаандаа гарах, иргэдийн зөрчигдсөн эрхийг хангаж хамгаалах ажлыг хуульд заасны дагуу ил тод, түргэн шуурхай хэрэгжүүлэхэд шүүхийн тамгын газраас бүхий л нөхцөл боломжоор хангаж, цагдаагийн байгууллагаас холбогдох сургалт, мэдээллийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажилласан.

Тайлант хугацаанд шүүгчийн хараат бус байдалд халдсан, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлсөн, нөлөөлөхийг оролдсон тохиолдол гараагүй, шүүгч нараас нөлөөллийн мэдүүлэг хөтөлж ирүүлээгүй бөгөөд шүүхийн тамгын газраас цагдаагийн байгууллагатай нягт хамтарч ажиллаж байгаа нь үр дүнд хүрч байна гэж үзэж байна.

2.4. Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

2.4.1. Шүүхийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн төслийг тус шүүхийн сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны зардал, зах зээлийн үнийн өсөлт, бараа материалын үнэ ханш, бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, үндэслэл, журмын дагуу боловсруулан 2025 оны төсвийн төсөл, 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус гарган Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх ажлыг зохион байгуулаа.

2.4.2. 2024 оны жилийн эцсийн байдлаар 1,095,947,100 төгрөгийн санхүүжилт авсан. Үүнд:

Цалин хөлс 1,044,842,500

Ажил олгогчоос НД төлөх шимтгэл 85,810,434.84

Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 21,860,620.00

Хангамж бараа материалын зардалд 39,628,888

Нормативд зардал 1,200,000

Эд хогшил урсгал засвар 40,500,720

Томилолт зочны зардал 10,090,000

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 13,279,886 төгрөгийг тус тус улсын төсвөөс санхүүжилтээр авчээ.

2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар нийт санхүүжилтийн 90% зарцуулсан гүйцэтгэлтэй байна.



2.4.3. Цалин хөлсийг МУ-ын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоол, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 72 дугаартай тушаалыг баримтлан тооцоолж байгаа ба батлагдсан цалингийн сан, орон тоонд багтаан цалин хөлсийг ТАЦНС-ээр цалинг тооцоолон олгож буй бөгөөд тайлант хугацаанд үндсэн цалинд 393,8 сая, ур чадварын нэмэгдэлд 205,4 сая, унаа хоолны хөнгөлөлтөд 57,3 сая, үр дүнгийн урамшуулалд 21,4 сая төгрөг нийт 678,1 сая төгрөгийн цалинг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгож санхүүгийн тайланд бүрэн тусгасан байна. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны цалингаас холбогдох татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тооцож, өр, авлагагүй ажиллаж байна.

2.4.4. Тус шүүхийн тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж, төсвийн ерөнхийлөн захирагчид чухал шаардлагатай мэдээ, тайлан, судалгааг тогтоосон хугацааны дотор гарган ажиллаж байна. Тайлант хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү хөрөнгө оруулалтын газарт 2025 оны төсвийн төсөл, шүүхийн захиргааны ажилтнуудын цалингийн судалгаа болон захиргааны албан тушаалтнуудын цалингийн нэмэгдлийн судалгааг гаргаж хүргүүлсэн байна.

2.4.5. Нягтлан бодох бүртгэлийн дагуу анхан шатны баримт /төлбөрийн хүсэлт, нэхэмжлэл, зарлагын баримт, е-баримт/-ын бүрдлийг хангаж ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд байгууллагын галлагаанд 15,8 сая төгрөгийн мод, нүүрс , 16,5 сая төгрөгийн бензин шатахуун, 608,5 мянган төгрөгийн байгууллагын хог ачуулсан 4,5 сая төгрөгийн аж ахуйн материал, 17,2 сая төгрөгийн урсгал засварын материал, 12,3

сая төгрөгийн бичиг хэргийн материал, 24,7 сая багаж, техник хэрэгсэл, 11,7 сая бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж, 913,0 мянган төгрөгийн мэдээлэл, технологийн үйлчилгээ, 9,2 сая төгрөгийн шуудан холбоо, интернэтийн зардал, 6,054 сая төгрөгийн гэрэл цахилгаан, 1,2 сая нормын хувцас зэрэг худалдан авах ажиллагааг хийж гүйцэтгэхэд анхан шатны баримтыг бүрдлийг бүрэн хангуулан ажилласан байна.

2.4.6. Тайлант хугацаанд тус шүүхийн тамгын газраас www.tender.gov.mn цахим хуудсыг ашиглан худалдан авах ажиллагаа явуулаагүй.



2.4.7. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудаст 2023 оны бүтэн жилийн тайлан, 2024 оны 1, 2, 3-р улирлын тайлан болон сар бүрийн санхүүгийн тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулан ажиллаж байна. 2024 онд нийт 121 мэдээг хуулийн хугацаанд, төсвийн гүйцэтгэл 1 удаа, бусад мэдээлэл 1 нийт 2 удаа хугацаа хэтрүүлсэн байна.

2.4.8. Тус шүүхийн тамгын газраас төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох дүрэм, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн ажиллаж байна.

2.4.9. Шүүхийн эд хөрөнгийг хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэн бүртгэж, нягтлан бодох бүртгэлийн программаас хэвлэсэн эд хариуцагчийн картын дагуу эд хөрөнгөтэй тулган тоолж баталгаажуулан, эд хөрөнгийн тооллогыг хийсэн. 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/13 дугаартай “Эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг томилох тухай” тушаалаар томилогдсон, Шүүгчийн туслах Б.Энхриймаагаар ахлуулсан тооллогын комисс 2024 оны хагас жилийн тооллогыг 06-р сарын 22 ны өдрөөс 06-р сарын 27 ны өдрүүдэд хийж, 2024 оны 06 дугаар сарын 28 ны өдөр илтгэх хуудсаар танилцуулсан байна. 2024 оны бүтэн жилийн тооллогыг 2024 оны 12-р сард багтаан хийхээр төлөвлөн ажиллаж байна. Шүүгч, албан хаагч нартай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулан, шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг ханган ажилласан.

2.4.10. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, албан тасалгааг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх ажлын хүрээнд батлагдсан төсвөөс 4,950,000 төгрөгөөр шинээр суурин компьютер 1 ширхэг, төгрөгөөр принтер 2 ширхэг, 17,400,000 төгрөгөөр ОХУ-д үйлдвэрлэсэн, SUKOPLAM PR 20-80 kw маркийн халаалтын шинэ зуух, 2,389,500 төгрөгөөр шугамын насос шинээр худалдан авсан байна.

2.4.11. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 612 дугаартай Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй цаашид ашиглах боломжгүй 36 нэрийн нийт 37,837,152.66 төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг данснаас хасахыг зөвшөөрсөн тухай тогтоолын дагуу акталж, данснаас хасах ажлыг зохион байгуулж, сандал 98H22B 20 ширхэг, ASER компьютер 5 ширхэг эдгээр хөрөнгийг сэлбэг, материал хоёрдогч түүхий эд болгон ашиглах, 6.4.4-т хөрөнгийг акталж данснаас хасахдаа шууд устгана гэж заасны дагуу буйдан кресло 1 ширхэг, цонхны хөшиг 2 ширхэг, хөшиг 20 ширхэг, өлгөдөг тумбочка 1 ширхэг, дугуйтай тумбочка 3 ширхэг, дугуйтай сандал 3 ширхэг, тавилгатай нууц цоож 1 ширхэг, DM-1035 сандал 1 ширхэг, DM-142 сандал 1 ширхэг, хувцасны өлгүүр 2 ширхэг сандал 98H22B 16 ширхэг, KC-A654-3TG chair 2 ширхэг, хайрцаг 1 ширхэг, компьютер DELL-3020 1 ширхэг, дотор кабель 2 ширхэг, гадна кабель 2 ширхэг, тогны утас 350 ширхэг, сүлжээний толгой төмөр 35 ширхэг, далдлагч 50 ширхэг, сүлжээ салаалагч 1 ширхэг, телефон аппарат 1 ширхэг, тог бууруулагч 11 ширхэг, сүлжээний гадна камер 6 ширхэг, сүлжээний дотор камер 5 ширхэг, принтер M1212 2 ширхэг, Samsung-3400 принт 1 ширхэг, Dell PC 1 ширхэг, канон 1 ширхэг, Dell optiplex-3010 1 ширхэг, ASER компьютер 7 ширхэг, BSB компьютер 1 ширхэг, зөөврийн компьютер hp 1 ширхэг, мотор Yamaha 1 ширхэг, зөөврийн компьютер 1 ширхэг, хөл TH-X 1 ширхэг, камер /Panasonic HC-VX985/ 1 ширхэг хөрөнгүүдийг устгаж, шийдвэрийн биелэлтийг хангаж ажилласан.

2.4.12. Тус шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, гарын авлага, бичиг хэрэгсэл /бичгийн цаас, принтерийн хор/ зэрэг бусад шаардлагатай материалаар хангах ажлыг зохион байгуулж 2024 оны жилийн эцсийн байдлаар хангамж бараа материалын зардалд 16,8 сая төгрөгийн зардал гаргасан байна.

2.4.13. Тухайн шүүхийн тамгын газар нь 2 автомашинтай бөгөөд Тоёота Прадо-150 маркийн автомашиныг 2013 онд хүлээн авсан бөгөөд засвар үйлчилгээ тогтмол хийгдэж байна. Тайлант хугацаанд Прадо-150 автомашинд масло кропны шингэн сольж 4 амортизатор, гарны түлк, кришигний жийрэг, рулийн аппарат зэргийг солиулж, засварын ажил хийгдсэн.

2.4.14. Тухайн шүүхийн 2 автомашиныг тээврийн хэрэгслийн хяналтын үзлэг, тооллогод тухай бүр бэлтгэн 2024.05.15-ны өдөр үзлэг оношилгоонд хамруулсан бөгөөд автомашины ашиглалт, техникийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж байна.

2.4.15. Тус шүүхийн тамгын газрын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, худалдан авах ажиллагааны тайлан, эрүүл мэнд, нийгмийн даатгал болон хувь хүний орлогын албан татварын тайланг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлэн ямар нэг алдаа зөрчилгүй ажиллаж байна.





ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн санхүү эдийн засгийн баталгааг хангах хүрээнд Төрийн хэмнэлтийн хуулийг дагуу төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр дүнтэй, хэмнэлттэй зарцуулан ажиллалаа.

Шүүхийн шүүн таслах ажиллагааг хэвийн тогтвортой явуулах шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын цалин хөлсийг тогтоосон хугацаанд олгох, холбогдох татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тооцох, албан томилолтоор ажиллах үеийн томилолтын зардлыг тооцох, шүүхийн байрны халаалт дулаан, цахилгааныг тогтвортой байлгах, автомашины бэлэн байдлыг хангуулах, шүүхийн захиргааны ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх, үр дүнгийн болон ур чадварын нэмэгдлийг зөв шударга тогтоож олгох, шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын ажиллах орчныг сайжруулах, чухал шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах, урсгал засварын үйлчилгээг цаг тухайд нь хийх зэрэг ажил, үйлчилгээнд анхаарал хандуулан ажилласан.

Тайлант хугацаанд төсөв санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хуульд заасан хугацаанд нь хүргүүлэх, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв байршуулах, сар бүрийн санхүүжилтийг чухал

шаардлагатай зүйлд зарцуулж, шүүхийн байрны иргэдэд үйлчлэх хэсэгт их засварын ажлыг шүүхийн захиргааны ажилтнуудын хүчээр хийж гүйцэтгэлээ.

2.5. Мэдээллээр хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ



2.5.1. Тус шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч нараас цахим хуудсыг шинээр хийлгэх ажлын хөлс болох 1,500,000 төгрөгийг гаргаж өгч, шинэ цахим хуудсыг 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хэвийн ажиллагааг тогтмол хангаж, 2024 оны шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, шүүхийн тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2023 оны шүүн ажиллагааны бүтэн жилийн мэдээ, 2024 оны шүүн таслах ажиллагааны эрүү, иргэн, зөрчлийн мэдээ, иргэдийн төлөөлөгчдийн оролцооны мэдээ, эвлэрүүлэн зуучлалын 2023 оны бүтэн жилийн мэдээ, 2024 оны хагас жилийн мэдээний тойм, 2024 оны 1-3 дугаар улирлын мэдээний тойм, шүүхийн тамгын газраас 2024 онд хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл, шүүхийн шийдвэрийн тойм зэрэг нийт 154 мэдээ, мэдээллүүдийг цахим сайт болон фейж хуудас, мэдээллийн самбарт оруулан иргэд олон нийтэд түгээн ажилласан байна.



2.5.2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020.09.01-ний өдрийн 102 дугаар тушаалаар батлагдсан “Шүүх хуралдааны явцыг мэдээлэх, цахим систем ашиглах журам”-ын 1.6.2, 3.1.4-т заасны дагуу Иргэний хэргийн 157, Эрүү, зөрчлийн хэргийн 1247, Цагдан хорих 22, Хянан магадлангийн 3 нийт **1429** товыг тухай бүр цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан ажилласан.

2.5.3. Нийт шүүгчийн чуулганы 2021.10.11-ний өдрийн 05 дугаартай тогтоолоор батлагдсан “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журам”, тус шүүхийн 2023.12.27-ны өдрийн 01 дугаартай “Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол”-ыг цахим хуудаст байршуулан ажилласан байна.

2.5.4. Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх дэх Эвлэрүүлэн зуучлалын цахим хаягаар нийт 72 мэдээ мэдээлэл олон нийтэд нийтэлж хуваалцсан байна. Мэдээллийн самбарт нийт шүүх хуралдааны тов болон иргэдэд өгөх эрх зүйн мэдээллийг байршуулж, шүүх дэх Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар пэйж хуудас нээж, тойргийн сумдын иргэдийн facebook группт шторк, болон шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг тогтмол мэдээлж байна.



2.5.5. Шүүхэд гаргах нэхэмжлэлийн загвар, бүрдүүлбэр, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн холбогдох заалт, торгууль, хураамж төлөх банкны дансны дугаар зэрэг мэдээллийг цахим хуудас, байршуулж шинэчлэл өөрчлөлтийг тухай бүр хийж байна.









2.5.6 2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 5 иргэдийн төлөөлөгч эрүү, иргэн шүүх хуралдаанд оролцсон байна. Уг иргэдийн төлөөлөгчийн оролцооны мэдээллийг шүүхийн цахим хуудаст байршуулж ажилласан.

2.5.7. Тус шүүхийн тамгын газрын **2016-2023** оны үйл ажиллагааны тайланг өөрийн шүүхийн цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтийг шүүхийн үйл ажиллагаатай ил тод нээлттэй танилцах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

2.5.8. Хуульд тусгайлан зааснаас бусад нээлттэй шүүх хуралдааны үйл ажиллагааг үзэж сонирхох боломжийг олгож тухайн шүүхэд явагдаж буй нээлттэй хуралдааныг шүүхийн үүдний дэлгэцээр дамжуулан гаргадаг бөгөөд иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн ажилтныг шүүх хуралдааны дэгд заасны дагуу оролцуулах боломжоор ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд нээлттэй шүүх хуралдаанд **19** иргэн биечлэн оролцсон байна.

2.5.9. Тус шүүхээр хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаарх төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нуцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж **24** шийдвэр, процессын тоймыг шүүхийн цахим сайт болон фейж хуудсаар мэдээлэл түгээж ажиллалаа.



2.5.10. Тайлант хугацаанд төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нуцад хамаарахаас бусад шүүх хуралдааныг цахимаар болон телевизээр нэвтрүүлэх тухай хүсэлт ирүүлээгүй бөгөөд ямар нэгэн телевиз болон цахим сайт, хэвлэл мэдээллийн байгууллагаар шүүх хуралдааны талаар мэдээ, мэдээлэл гараагүй.

2.5.11. 2024.05.27-ны өдөр Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шүүх байгууллагын тухай танилцуулга хийж, танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 8 дугаар ангийн 21 сурагчид хамрагдаж, 1, 2-р байр эзлүүлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан байна.

2.5.12. Иргэдийн эрх зүйн боловсролд зориулж Шүүхийн захиргааны ажилтан дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээний талаар мэдээлэл бэлтгэж шүүхийн фэйж хуудсанд байршуулан ажилласан.



2.5.13. Иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор “байгаль орчин, амьтан ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил”, “хүүхдийн эсрэг гэмт хэрэг”, “нийтийн хэв журам аюулгүй байдлын эсрэг зөрчил”, “Нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил” гарын авлага бэлтгэж, шүүхийн үйлчилгээний хэсгийн самбарт байршуулсан.

2.5.14. Завхан аймгийн Тосонцэнгэл сумын ЕБС-ын 1-5 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан **“Цодгор хүү”** шатарын сорилго тэмцээнд хурд хүч, авъяас чадвар, авхаалж самбаа, торгон мэдрэмж гарган амжилттай оролцсон хүүхдүүдэд шагнал гардуулсан. Уг тэмцээнд хоёр ихэр хүүхэд шагналт байранд орсон нь онцлох үйл явдал байлаа.

2.5.15. 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдөр сумын байгаль орчны газраас өгсөн 34 ширхэг шар хуайс модны суулгацыг байгууллагын хашаанд тарьсан байна.



2.5.16. Ерөнхий зөвлөлөөс гарсан шийдвэр тогтоолыг мэдээллийн сан өөрсдийн дотоод сүлжээнд үүсгэж тухай бүр шүүгч, ажилтнуудад танилцуулах арга хэмжээ авч, шүүхийн захиргааны ажилтнууд мэдээлэл авсан талаар гарын үсэг зурж баталгаажуулдаг бөгөөд тухайн шүүхийн шүүн таслах болон бусад ажиллагааны талаарх мэдээллийн шүүхийн цахим хаяг болон фейж хуудсанд байршуулж, тойргийн сумдын тамгын газрын байранд байрлах мэдээллийн самбар, ажиллах тохиолдолд иргэд олон нийтэд тухай бүр мэдээлэл өгч ажилласан байна.

ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тайлант хугацаанд тус шүүхийн тамгын газраас иргэд олон нийтэд чиглэсэн, шүүхийн үйл ажиллагаа, ололт амжилтын талаар нээлттэй өдөрлөг зохион байгуулах, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахаар төлөвлөж ажилласан.

Тус шүүхийн тамгын газар нь тойргийн 9 суманд нээлттэй өдөрлөг зохион байгуулж, иргэд олон нийтэд шүүн таслах ажиллагаа, шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа, шүүхийн иргэдийн төлөөлөгч, эвлэрүүлэн зуучлалын талаар тодорхой мэдээлэл өгч ажилласан нь иргэдийн сонирхлыг татсан шүүхийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаар мэдээлэл авсан ач холбогдолтой арга хэмжээ болж чадсан.

ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ САЙЖРУУЛАХ САНАЛ

Тус шүүхийн тамгын газраас шүүгч, шүүхийн захиргааны ажилтан албан хаагчдын гаргасан санал санаачилагыг дэмжиж, шүүхийн шүүн таслах ажиллагааг хэвийн тогтвортой, тасралтгүй явуулах, хэргийн хөдөлгөөнд гарч буй алдаа зөрчлийг арилгах, дахин давтан гаргуулахгүй байх, шүүгч, ажилтнуудын ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, шүүхийн байранд их засварын ажлыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан гүйцэтгэж , шүүхийн үйл ажиллагаа, ололт амжилтыг иргэд, олон нийтэд сурталчлах, шүүхээр үйлчлүүлж буй иргэдэд чанартай, мэдрэмжтэй үйлчилгээг ил тод, түргэн шуурхай үзүүлэх зэрэг олон арга хэмжээг амжилттай биелүүлж ажиллалаа.

Бид иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг хангах зорилгоор тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шүүхийн цахим хуудсыг шинэчилж, иргэдийн эрх зүйн боловсролд зориулсан мэдээллүүдийг түгээж ажиллалаа.

Мөн шүүхийн үйлчилгээний хэгсийг мэдээлэл авахад тав тухтай болгон засварлаж, иргэдэд мэдээлэл лавлагаа болон архивын үйлчилгээг нэг дороос үзүүлэх боломжтой болголоо.

Шүүн таслах ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, албан тасалгааг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх ажлын хүрээнд байгууллагын нам даралтын зуух, насос шинээр сольж, суурилуулсан.

Тус шүүхийн тамгын газар дотоод нөөц бололцоондоо тулгуурлан архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлж, архивд хадгалагдаж буй 8,695 хадгаламж нэгжийг бүрэн цахимжуулсан.

Хадгалах хугацаа дууссан архивын баримтын жагсаалтыг холбогдох байгууллагаар батлуулж, иргэний 3228 хэрэг, зөрчлийн 988 хэргийг устгаж ажиллалаа.

Прокурорын газарт түр хадгалах эрүүгийн хэрэг 425, зөрчлийн хэрэг 1287, шийтгэх тогтоолын өнгөн хувь 45, шийтгэврийн өнгөн хувь 3, зөрчлийн шүүгчийн захирамжийн өнгөн хувь 2, ерөнхий шүүгчийн захирамжийн өнгөн хувь 1 нийт 1763 хадгаламж нэгжийг шилжүүлсэн байна.

Завхан аймгийн Тосонцэнгэл сум нь Монгол улсын хамгийн хүйтэн газруудын нэг бөгөөд цаг агаарын эрс тэс, хүйтэн нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг өвөлдөө -45-аас -52 хэм хүртэл хүйтэрдэг. 2021 онд ШЕЗ-өөс олгосон “Renualt duster” автомашин нь тус суманд өвлийн улиралд ашиглахад тохиромжгүй, хэт хүйтэнд

асдаггүй, “Prado-150” 2013 онд тус шүүхийн шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхээр үйлчилгээнд явж эхэлсэн, ашиглалтын хугацаа дуусан, тойргийн сумдад шүүхийн үйлчилгээг хүргэх, мөн шүүгч шүүх бүрэлдэхүүнд ажиллахад хүндрэлтэй байгаа тул албаны автомашины парк шинэчлэлт хийх шаардлагатай байна.

Тус шүүхийн тамгын газрын дэргэдэх ёс зүйн дэд хороонд 2024 онд нийт 2 гомдлыг шүүхийн захиргааны буюу төрийн жинхэнэ албан хаагчид холбогдуулан гаргасан байна. Тамгын газрын даргын тушаалаар 1 албан хаагчид “Нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах” сахилгын шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн байна. Ёс зүйн дэд хорооны зүгээс 1 гомдлыг хуульд заасан шалгах хугацаа хэтэрсэн байх тул гомдлыг буцааж шийдвэрлэсэн байна. 2025 онд шүүхийн захиргааны ажилтнуудын харилцаа хандлагыг сайжруулах талаар бодитой ажил хэрэгжүүлэх, ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг ёс зүйн дэд хорооны даргад үүрэг болголоо.

Цаашид энэхүү хүрсэн амжилтаа улам бүр бататгаж, алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дахин давтан гаргахгүй байх 2025 онд дэвшүүлсэн зорилго, зорилтыг биелүүлэхийн төлөө хамтарч ажиллахаар төлөвлөж байна.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭНХЦЭЦЭГ